



ХУУЛИА МЭДЬЕ- ЭРХЭЭ ХАМГААЛЪЯ

**Хааалтын үе шат- иргэдийн эрхээ хамгаалахад
зориулсан хууль тогтоомжийн тайлбар**

УЛААНБААТАР ХОТ
2021 ОН

ХУУЛИА МЭДЬЕ-ЭРХЭЭ ХАМГААЛЪЯ

Хаалтын үе шат- иргэдийн эрхээ хамгаалахад
зориулсан хууль тогтоомжийн тайлбар

Эмхэтгэсэн:	“Хил хязгааргүй алхам” ТББ
Хянасан:	“МОНЭС” (Монголын эмэгтэйчүүдийн сан)
Хэвлэлийн дизайн:	Б.Цэрэнлхам
Хэвлэсэн газар:	“Мөнхийн үсэг” ХХК
Хэвлэсэн он:	2021 он

ГАРЧИГ

Нэгдүгээр бүлэг ХҮНИЙ ЭРХ		
1.1.	Хүний эрхийн зарчим	8
1.2.	Хүний эрхийн төрөл	9
1.3.	Уул уурхай ба хүний эрх	13
Хоёрдугаар бүлэг. АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ		
2.1.	Уул уурхайн хаалт гэж юу вэ?	21
2.2.	Хаалтын үйл ажиллагааг төлөвлөх үе	22
2.3.	Уурхайн хаалтын бэлтгэл шат	24
2.4.	Уул уурхайн хаалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх шат	26
2.5.	Уул уурхайн хаалт, хаалтыг хүлээн авах шат	26
2.6.	Уурхайн хаалт дахь иргэд олон нийтийн оролцоо	28
Гуравдугаар бүлэг БОДИТ ЖИШЭЭ		
3.1.	Шигтгээ 1. Монполимент ХХК-ийн сайн туршлага	29
3.2.	Шигтгээ 2. ХОБОМ-хамтын оролцоотой байгаль орчны мониторинг	31
Дөрөвдүгээр бүлэг АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ТОГТООМЖ		
4.1.	Олборлох салбарын хууль, тогтоомжууд	35
4.2.	Байгаль орчны салбарын багц хууль, тогтоомжууд	38
4.3.	Өргөдөл гомдол гаргахтай холбоотой хууль, тогтоомжууд	42
4.4.	ОУ-ын гэрээ, конвенц	47
4.5.	Холбогдох дүрэм журам	55
4.6.	Мэдээлэл авах цахим хуудсууд	56

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УИХ	Улсын их хурал
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
НҮТББ	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
БОННУ	Байгаль орчинд нөлөөлөх нарийвчилсан үнэлгээ
Багийн ИНХ	Багийн Иргэдийн Нийтийн Хурал
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
ОХШХ	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

ӨМНӨХ ҮГ

Энэхүү гарын авлагыг уул уурхайн олборлолтын үйл ажиллагааны нөлөөлөл бүхий нутаг дэвсгэрийн оршин суугчид болон эх орон, газар нутгаа хүндэлж, хайрлан хамгаалахыг эрмэлздэг хэн бүхэнд зориулан боловсруулав.

Манай орны байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн доройтол нь хүний үйл ажиллагааны улмаас маш хурдацтай доройтож байна. Ялангуяа иргэдийн хяналтгүй, хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагааны улмаас ундны усны үндсэн эх үүсвэр болох гол, мөрөн их хэмжээгээр бохирдож, ширгэж байна. Энэ нь зөвхөн хөрс, агаар, ус, байгаль орчинд нөлөөлөөд зогсохгүй уламжлалт мал аж ахуй эрхлэх боломжгүй болох, эрүүл мэндэд эрсдэл учруулах зэрэг ноцтой үр дагавартай. Экологийн доройтол, байгалийн үр шим багасах, хүрээлэн буй орчин бохирдох нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчин, эрүүл мэндэд хортой нөлөөлөл үзүүлж байна.

Танай нутагт уул уурхайн үйл ажиллагаа хүний эрхийн, байгаль орчны, нийгмийн хөгжилд сөрөг, хортой үл мөр үлдээхгүй байх зорилгоор Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Цөмийн /ураны/ энергийн тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах багц 30 гаран хууль, мөн иргэдийн мэдээлэл авах, өргөдөл гомдол гаргах, шүүхээр эрхээ сэргээлгэх харилцааг зохицуулсан хууль тогтоомж өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Үндсэн хууль болон Олон улсын хэмжээнд хүний эрхийг бизнесээс хамгаалах, бизнесийнхэн хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх хууль зүйн баталгааг гаргах үүргийг Засгийн газарт

хүлээлгэсэн. Тодруулбал, Засгийн газар нь иргэдийнхээ эрх, эрх чөлөөг бизнесээс хамгаалах хууль тогтоомж гаргах, хяналт тавих, хариуцлага тооцох замаар хүний эрх, эрх чөлөөг бүрэн хамгаалж, хангах үүрэг хүлээнэ. Харин бизнесийн байгууллагад хүний эрхийг зөрчихгүй, дордуулахгүй, хөндөхгүй хүндэтгэх, дэмжих үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ хэрэгжүүлж байгаад төр нь хяналт тавьж хариуцлага тооцох, зөрчсөн тохиолдолд шүүхээр болон шүүхийн бус хэлбэрээр эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлөх үүргийг хуулиар баталгаажуулах үүрэгтэй.

Монголчуудын аж ахуй, уламжлалт соёл нь байгаль орчин, газар нутгийн аюулгүй байдалтай салшгүй холбоотой. Энэ утгаараа эх нутгаа хайрлах, энэрэх, хамгаалах чин сэтгэл хэн бүхэнд байдаг. Сүүлийн үед байгаль орчин, аж ахуй соёлоо хайрлах, хамгаалах иргэдийн идэвхи улам сайжирч, олон төрийн бус байгууллагууд, бүлгүүд байгуулагдан байгаль хамгаалах үйл хэрэгт хувь нэмрээ оруулж байна. Гэхдээ хүн бүхэн хэрхэн, ямар аргаар уг үйл ажиллагаанд оролцох вэ гэдгээ мэдэх боломж нь хомс юм. Тийм учраас энэхүү гарын авлагыг иргэд, тэр дундаа малчин эмэгтэйчүүдийн хуулийн мэдлэгийг нэмэгдүүлэх, тэд эрхээ хамгаалахдаа хууль ашиглах мэдлэг, ур чадварыг дэмжих зорилгоор бэлтгэсэн болно.

Уг гарын авлагын 1-р бүлэгт Хүний эрх, эрх чөлөө гэж юу вэ? Иргэд бид тэрхүү эрх, эрх чөлөө зөрчигдөж байгаа эсэхийг хэрхэн танин мэдэх, зөрчлийг баримтжуулах болон хүний эрхийн талаарх үндэсний болон ОУ-ын хууль зүйн тайлбар орууллаа. 2-р бүлэгт Үндэсний хууль тогтоомжуудыг иргэн танд зориулж хялбаршуулан тайлбарлаж зарим жишээгээр тодруулж ойлгомжтой болгохыг зорилоо. Харин

3-р бүлэгт уул уурхай бүхий нутгийн иргэд хууль тогтоомжийг хэрхэн ашиглаж үр дүнд хүрсэн амжилт бас сургамжийн бодит амьдралыг түүхчлэн бичиж, зурж харууллаа. 4-р бүлэгт салбарын бүхий л гол гол хууль тогтоомжуудын заалтуудыг түүж ач холбогдолыг тайлбарлаж багтаалаа.

МУ-ын Үндсэн хуульд 2019 онд байгалийн нөөц ашиглахтай холбоотой томоохон шинэчлэлийн заалтууд орсонтой холбоотой Ашигт малтмалын тухай багц хуулийн (УУХҮЯ), Байгаль орчны (БОАЖЯ), Газрын тухай багц хуулиудад (БХБЯ) нэмэлт өөрчлөлтүүд оруулах үйл явц ид өрнөж байна. Ийм учраас энэхүү гарын авлагыг тун удахгүй дахин шинэчлэн сайжруулах шаардлага гарна.

Энэхүү гарын авлагыг МОНЭС-ийн “Эмэгтэйчүүдийн эрх ба байгаль орчны шударга ёс” чиглэлээр хэрэгжүүлсэн

төслүүдийн хүрээнд эмэгтэйчүүдийн бүлгүүдийн хууль эрх зүйн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, нөлөөлөл хийх чадавхыг бэхжүүлэх зорилгоор боловсруулсан бөгөөд иргэн таны эх орон, байгаль орчноо хамгаалах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхээ хэрэгжүүлэх, учирсан хохирлоо барагдуулах үйл ажиллагаанд бодит хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна болно. Санүүгийн дэмжлэг үзүүлсэн NTFP-EP (Non-timber forest products) байгууллагад талархал илэрхийлье. Гарын авлага нь санхүүжүүлэгч байгууллагын байр суурийг илтгэхгүй болно.

Мөн уул уурхайн салбарын харилцааг зохицуулсан хууль тогтоомжуудыг иргэдэд ойлгомжтой байдлаар хялбаршуулан боловсруулсан Хил хязгааргүй алхам ТББ, түншлэгч Эл Би Партнерс өмгөөллийн ХХН-ний хуульчдад гүн талархал илэрхийлье.

*Тус гарын авлагатай холбоотой санал, асуулт зөвлөгөө авах бол:
Хил хязгааргүй алхам ТББ-ын дараахь хаягаар холбогдоно уу.*



7000-6061
8872-4869



swb.ngo@gmail.com

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ХҮНИЙ ЭРХ

Энэ гарын авлагад “Хүний эрх”-ийн тухай өгүүлэхдээ “Таны эрх”-ийг хэрэгжүүлэх, таныг, танай гэр бүл, нутгийн хамт олныг уул уурхайн бизнесээс хамгаалах тухай хууль тогтоомж, түүнийг хэрхэн ашиглах тухай мэдлэг, ур чадвар олгоход чиглэх юм.

Та бол зүүний үзүүрт будаа тогтох төдий тэр агшинд хүн болж төрсөн тул та хүний ёсоор хүндлэгдэж, сайн сайхан амьдрах таатай орчноор баталгаатай хангагдаж, хамгаалагдаж ажиллаж амьдрах ёстой бөгөөд таныг хаана ч ямар ч ажил эрхэлж, амьдарч байхаас үл хамаараад таны эрхийг хэн нэгэн хөндөх, дордуулах ёсгүй. Та ч бусдын эрх, эрх чөлөөг хөндөх, зөрчих ёсгүй. Уул уурхайн бизнес хийж байгаа компани таны болон таны гэр бүлийн халдашгүй байдал, амьдрах орчныг дордуулсан аливаа үйлдэл хийх ёсгүй. Үүнийг төр хууль дүрэм тогтоож, түүнийг зөрчвөл хариуцлага тооцож, бизнесийг зогсоож хүртэл хүн бүрийн, өрх гэр бүлийн эрх, эрх чөлөөг баталгаатай хамгаалсан тогтолцоог бүрдүүлэх үүрэгтэй. Иймд хүний эрх, эрх чөлөө хэзээ ч, хаана ч зөрчигдөх ёсгүй,

төрийн хамгаалалтаас гадна үлдэх ёсгүй.

Дэлхий дээр 200 гаран улс бий. Эдгээр улсууд олон улсын хууль, эдийн засгийн хөгжил, нийгэм болон экологийн аюулгүй байдал, хүний эрхийн талаар хамтран ажиллах зорилгоор 1945 онд Нэгдсэн үндэсний байгууллага (НҮБ) байгуулсан. НҮБ-ын гишүүн улсууд 1948 онд дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч чанд мөрдөх хүний эрхийн наад захын стандарт тогтоосон Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ) стандарт дүрмийг гаргасан байдаг. Тус тунхаглалыг дэлхийн бүх улс орон даган мөрдөх үүрэгтэй төдийгүй харилцан биендээ зөвлөдөг, улс төрийн төвшний шахалт үзүүлж шаардах байдлаар хэрэгжилтийг хангадаг.

Энэ тунхаглалд зааснаар Хүний эрх гэдэг бол хэн нэгэн өрөөлийн асуудлыг бус харин тантай салшгүй холбоотой, таны хүн болж төрсний хувьд, төрөхөөс заяагдсан, ямар нэгэн ялгаатай байдлаасаа үл хамааран эдэлбэл зохих, эрхэмсэг, хүн шиг байх эрх, эрх чөлөөг хэлдэг.



1.1. ХҮНИЙ ЭРХИЙН ЗАРЧИМ

Нэгдсэн үндэстний байгууллага нь аюулгүй байдал, хөгжил, хүний эрх мөн хүрээлэн буй орчин гэсэн дөрвөн үнэт зүйлсийг эрхэмлэдэг бөгөөд дараах үндсэн гурван зарчмыг баримталдаг.

Нэгдүгээр зарчим-ХАМГААЛ.

Төр нь зохистой бодлого, зохицуулалтаар хүний эрхийг гуравдагч талууд зөрчихөөс хамгаалах үүрэгтэй. Үүнд бизнесийн байгууллага ч хүний эрхийг хамгаалах үүрэг хүлээнэ.

Хоёрдугаар зарчим-ХҮНДЭЛ.

Аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрхийг хүндэтгэх үүрэг хүлээнэ. Энэ нь “үл хохироох” гэдэг зарчимд тулгуурлана. Аж ахуйн нэгж, байгууллага нь

эрсдэлийн судалгаа, нөлөөллийн үнэлгээ, хуулийг чанд мөрдөх зэрэг үйл ажиллагаагаараа хүний эрхийг зөрчихөөс сэргийлэх ёстой. Аж ахуйн нэгж, байгууллага шууд бус байдлаар хүний эрхийг зөрчсөн үйл ажиллагаанд оролцох, хамааралтай байх нь энэ зарчимд харшилна.

Гуравдугаар зарчим-ЭРХИЙГ СЭРГЭЭ.

Эрх нь зөрчигдсөн иргэд буюу хохирогчид эрхээ хамгаалах шүүхийн ба шүүхийн бус тогтолцоог бий болгох шаардлагатай. Төр нь хуулийн хүрээнд хохирсон иргэдийн эрхийг хамгаалах, хохирлыг барагдуулах, гэм буруутай этгээдэд шүүх болон захиргааны аргаар хариуцлага тооцох ажлыг хариуцах ёстой.



1.2. ХҮНИЙ ЭРХИЙН ТӨРӨЛ

Хүний эрхийн үндсэн таван төрөл байдаг бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрхүүдийг улс төр, эрх зүйн шалгуураар нь гурав ангилж болно.

Үүнд:

Ангилсан эрхүүд	Иргэдийн байгаль орчны эрхтэй хэрхэн хамаатуулж ойлгох вэ?
<p>Хувийн эрх, эрх чөлөө: Иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөний дотор хувийн эрх, эрх чөлөө онцгой байрыг эзэлнэ. Хувийн эрх, эрх чөлөө гэдэг нь хүний хувийн амьдрал ахуйн хүрээнд шууд хамааралтай чухал нөхцөл, боломжийг хуульчлан тогтоосныг хэлнэ. Энэ нь зарим талаар хүний жам ёсны эрхтэй салшгүй холбоотой.</p>	
<p>Халдашгүй чөлөөтэй байх эрх Халдашгүй чөлөөтэй байх эрх нь: - Хувийн амьдрал халдашгүй байх; - Гэр бүл халдашгүй байх; - Орон байр халдашгүй байх; - Захидал харилцаа халдашгүй байх</p>	<p>Танай нутагт уул уурхайн төсөл хэрэгжиж байгаагаас шалтгаалан тэсэлгээний чичиргээ, химийн бодисын үнэр, усны бохирдол, тоосжилт үүсэх зэрэг тэвчиж амьдрах боломжгүй нөхцөлд хүргэх, эсхүл хохирол амсаж, сэтгэл зүйн хувьд дарамтад орж, чимээгүй гомдоллож амьдрахаас аргагүй нөхцөлд хүргэх нь таны урьд өмнө аюулгүй, айдасгүй байсан орчин, нөхцөлийг үгүй хийж, халдаж байгаа үйлдэл болно. Дээрх нөхцөл байдал нь таны төрөөр баталгаатай хамгаалуулсан байх эрх, эрх чөлөөг зөрчиж буй үйлдэл бөгөөд жам ёсны эрх буюу амьд явах эрхэд ч халдахаар байна.</p>
<p>Шүүхэд гомдол гаргах : Өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх. Энэхүү эрх нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүнлэг, энэрэнгүй байх зарчмын бодит илрэл болдог.</p>	<p>Хэрэв таны эрх, эрх чөлөөнд эрсдэл учруулж болзошгүй, эсхүл та болон таны гэр бүл, нутгийн иргэдийн эрх зөрчигдсөн тохиолдолд шүүхэд хандаж зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжтой. Энэ тохиолдолд та өөрөө эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан шүүхэд нэхэмжлэл гаргаж зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээс гадна өөрт учирсан хохирлоо арилгуулах, төрийн байгууллагын хууль бус шийдвэрийг хүчингүй болгуулж болно.</p>
<p>Өмгөөлүүлэх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрх Монгол Улсын иргэд: - Эрүү, иргэн, захиргааны хэрэгт оролцохдоо өөрийн эрх ашгийг хамгаалуулах; - Үүний тулд хууль зүйн мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа авах, - Өмгөөлөгчөө өөрөө сонгох; - Хэрэгт холбогдсон үед чухам ямар үндэслэлээр шалгагдаж байгаага мэдэх, - Өөрийн гэм буруугүйг нотлох; - Ял шийтгэл хариуцлагыг хөнгөрүүлэх, цагаатгах нөхцөл байдлыг хангуулах; - Өөрийгөө өмгөөлөх замаар тухайн нотлох баримтыг шалгуулах зэрэг эрхтэй.</p>	

<p>Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрх Монгол Улсын иргэн нийгмийн амьдралд оролцоходоо:</p> <ul style="list-style-type: none"> - Өөрийн гэсэн үзэл бодолтой байх; - Түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх; - Өөртөө итгэл үнэмшилтэй байх; - Хурал цуглаанд оролцох, үг хэлэх, санал хүсэлт гаргах зэрэг эрхтэй. 	<p>Та Үндэсний хууль тогтоомж төдийгүй ОУ-ын хууль тогтоомж түүний дотор Хүний эрхийн түгээмэл тунхаглалд зааснаар эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах эрхтэй. Эдгээр эрхүүд тань хэрэгжиж байгаа эсэх, эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор итгэл үнэмшилтэйгээр үзэл бодлоо илэрхийлэх, эрхийг зөрчигдөхөөс хамгаалах зэргээр ирээдүйдээ итгэлтэй, зоримог байх хэрэгтэй. Таны амьдрах орчин уул уурхайн төслөөс өмнө ямар байсан, хэрхэн өөрчлөгдсөнийг та л хамгийн сайн мэднэ. Тиймээс та баг, сумын хурал, сошиал орчинд үзэл бодлоо үндэслэлтэйгээр илэрхийлэх, санал бодлоо хуваалцах, хариуцлага шаардаж эрхээ хамгаалах боломжтой. Харин хүн, хуулийн этгээдийг үндэслэлгүйгээр гүтгэх, бүдүүлэг үгээр гутаан доромжлох нь хуулиар хориглосон болохыг анхаарах хэрэгтэй.</p>
<p>Мэдээлэл хайх, хүлээн авах эрх Монгол Улсын иргэд:</p> <ul style="list-style-type: none"> - Өөрийн танин мэдэхүйн болон бусад шаардлагатай хэрэгцээгээ хангах; - Өөрт хэрэгтэй мэдээ, мэдээлэл хайж, түүнийг олж авах, цуглуулах, хүлээн авах; <p>Мэдээллээ боловсруулж ашиглах, зүй зохистой хэрэглэх зэрэг эрхтэй.</p> <p>Гэхдээ энэхүү мэдээлэл нь төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарах асуудлаар хязгаарласан байдаг. Түүнчлэн хувь хүн, байгууллагын нууцад хамааралгүй байх шаардлагатай.</p>	<p>Хүн бүр хуулиар нууцад хамруулсанаас бусад мэдээллийг авах эрхтэй. Төрөөс авч буй мэдээлэл нь цаг үе, агуулга, чанарын хувьд ашиглаж болохуйц хүртээмжтэй мэдээлэл байх ёстой. Тухайн мэдээллийг ямар зорилгоор авч байгаагаа иргэн хүн төрийн албан хаагчид тайлбарлахгүй байх эрхтэй.</p>
<p>Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр болон байнга оршин суух газраа сонгох. Монгол Улсын иргэн хэн боловч:</p> <ul style="list-style-type: none"> - Улсынхаа нутаг дэвсгэрт байнга буюу түр оршин сууж буй эсэхээс үл хамааран нийт нутаг дэвсгэртээ чөлөөтэй зорчих; - Түр буюу байнга оршин суух газар болон ажиллаж амьдрах байршлаа өөрөө чөлөөтэй сонгох эрхтэй. <p>Харин иргэдийн шилжилт хөдөлгөөн, байршил, харьяаллын нөхцөл, журмыг хуулиар тусгайлан зохицуулсан байдаг.</p>	<p>Манай улс нүүдлийн, бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг онцлогтой бөгөөд нүүдлийн соёл иргэншилд тулгуурлаж амьдарч ирсэн. Иймд уул уурхайгаас шалтгаалан бэлчээрээсээ шахагдан дайжих, бэлчээр хомсдох, усгүй болох зэрэг эрүүл аюулгүй орчинд амьдрах болон малчдын эдийн засгийн гол эх үүсвэрт сөрөг нөлөө үзүүлж байна. Энэ тохиолдолд Үндсэн хуульд заасан эрхээ хамгаалах боломжтой.</p>

Нийгэм, эдийн засгийн эрх:

Иргэдийн нийгэм, эдийн засгийн эрх гэдэг нь хүний нийгмийн харилцаанд оролцох, эд хөрөнгө өмчлөх, төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамжийг авахтай холбоотой бүхий л эрхийг ойлгоно.

Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрх

Хүн хэрэгцээгээ хангахын тулд:

- Аж амьдралын хэрэгцээт зүйлс, байр сууц, өвөлжөө, хаваржаа, машин техник, мөнгө, үнэт цаас, хөдлөх үл хөдлөх хөрөнгө /мал/ гэх мэт өмчтэй байх;
- Тэдгээрийг зориулалтаар нь хэрэглэх, ашиглах, өөрийн мэдэлд байлгах, захиран зарцуулах, хамгаалах;
- Үр хүүхэд, хууль ёсны төлөөлөгчдөд өвлүүлэх зэрэг эрхтэй болно.

Уул уурхайн ашиглалт, түүний тээвэрлэлтийн улмаас малчид ихэвчлэн сөрөг нөлөөлөлд өртөж, эрх ашиг нь хөндөгдөх нь элбэг байдаг.

Малчдын мал нь өрхийн бизнес, ажлын байр, өвлүүлэх өв хөрөнгө, өмч юм. Өмчийн эзний хувьд өмчөө ашиглах, хамгаалах хуулиар хамгаалагдсан эрхтэй. Үүнийг эдийн засгийн эрх ч гэж үздэг.

Хувийн аж ахуй эрхлэх эрх

Монгол Улсын иргэн хэн боловч:

- Хувиараа чөлөөтэй ажил хөдөлмөр эрхлэх;
- Түүнийхээ үр шимийг хүртэх;
- Ажиллах нөхцөл, боломжтой байх эрхтэй.

Хувийн аж ахуй эрхлэх эрх нь хувийн өмчтэй байх, түүнийгээ ашиглах, эзэмших, захиран зарцуулах, төдийгүй өв залгамжлуулах, бусдад худалдах зэрэг эрхтэй салшгүй холбоотой.

Харин өмчөө өсгөх, хамгаалах эрхийг хангаж, өвөлжөөний газрыг 15-60 жилийн хугацаатай эзэмших эрхийг олгож байна.

Иймд малчдын өмч, эзэмшлийн хөрөнгөд уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэлтэй ямар нэг эрсдэл учирвал түүнийг шүүхийн болон шүүхийн бус аргаар хамгаалах бүрэн эрх танд байгаа юм.

Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх

Хүн ямар ч үед:

- Эрүүл мэндийнхээ төлөө санаа тавьж, түүнийгээ хамгаалуулах;
- Эрүүл мэндээ хамгаалуулах нь эмнэлгийн тусламж авах, эмчлэн сувилуулах үйлчилгээгээр хангагдах бүрэн боломжтой байх;
- Эрүүл мэндийн даатгалтай нөхцөлд зохих хөнгөлөлт эдэлж эм, тариа, эмнэлгийн анхан шатны үйлчилгээгээр үнэ төлбөргүй хангагдах;

Иргэн бүр эрүүл мэндээ төрөөр хамгаалуулах эрхтэй.

Мөн уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэн таны эрүүл мэнд түүний орчин нөхцөл доройтох нь таны эрүүл мэндээ хамгаалуулах эрх зөрчигдөж байна гэсэн үг.

Та цэвэр усаар хангагдсан, дуу чимээ стандартаас хэтрээгүй, айх айдасгүй аюулгүй орчинд л ажиллаж, амьдрах ёстой.

Эрүүл мэндийн нөхцөл олон хүчин зүйлээс шалтгаалан өөрчлөгдөж байдаг.

Уул уурхайн төслийн хувьд дээрх нөхцөл байдал уул уурхайн төсөл хэрэгжихийн өмнөх үеэс дордох ёсгүй гэдгийг л анхаарах учиртай юм.

Улс төрийн эрх, эрх чөлөө:

Иргэн хүний нийгэм-улс төрийн эрх, эрх чөлөө бол тухайн хүний нийгмийн идэвх байр суурь, мөн чанарыг илтгэн харуулдаг.

Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийн удирдах үйл хэрэгт оролцох эрх

Төрийн байгууллагад сонгох сонгогдох эрх

төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрх

Хүйсийн тэгш байдал

Тайван замаар жагсаал цуглаан хийх эрх

Улс төрийн эрх, эрх чөлөө гэдгийг энэ сэдвийн хувьд уул уурхайн төсөл хэрэгжсэнээр таны эрх, эрх чөлөө болон байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж таны болон танай гэр бүл, нутгийн иргэдийн иргэний, эдийн засгийн, соёлын, нийгмийн, улс төрийн эрхийн тухайд:

- асуудлыг баримттайгаар шүүмжилж, шийдэл шаардаж болно.
- ИТХ, УИХ-д төлөөлсөн төлөөлөгчөөсөө иргэдийг төлөөлөх үүргийг шаардах эсхүл өөрөө ч нэрээ дэвшүүлж, иргэдийг төлөөлөн эрхийг нь хамгаалж болно.\
- Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж болно.
- Эрэгтэй, эмэгтэй, залуу, ахмад хэн ч аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхтэй
- Үзэл бодлоо хэвлэл мэдээллийн хэрэгсэлд чөлөөтэй илэрхийлж болно.
- Иргэдийг манлайлан зохион байгуулж, хуулийн хүрээнд тайван жагсаал цуглаан хийж болно.
- Өргөх бичиг, албан шаардлага гаргах, түүнд нэгдэх замаар эрх ашгаа хамгаалж болно.

ХУУЛИА МЭДЭЭ-ЭРХЭЭ ХАМГААЛБЯ



1.3. УУЛ УУРХАЙ БА ХҮНИЙ ЭРХ

Монголчууд бид дэлхийд уламжлалаа хадгалж үлдэж чадсан цорын ганц нүүдэлчин ард түмэн юм. Нүүдлийн мал аж ахуй нь уламжлан хадгалагддаг өрхийн бизнес, тухайн өрхийн үе дамжсан амьжиргааны эх үүсвэр болдог. Нүүдэлчдийн мал аж ахуй нь жилийн дөрвөн улирал, байгалийн онцлогтоо нийцсэн, хүн ба малын усны нөөц нь шийдэгдсэн өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн 4 байршил, түүнийг дагасан бэлчээр, хадлан, отрын талбайтай, цогц дэд бүтэц бүхий үндэсний үйлдвэрлэлийн нэгж болдог.

Нүүдэлчин аж ахуй нь хээр тал, урсгал ус болон гол горхи бэлчээрийн орчин эрүүл, аюулгүй байх нь малчдын амин сүнс болсон мал сүрэг, түүний сүү сүүн бүтээгдэхүүн,

мах нь эрүүл байх үндсэн нөхцөл болдог. Мал аж ахуйн бүтээгдэхүүн түүний орчин эрүүл, аюулгүй байх нь зөвхөн малчин өрхөд үнэ цэнэтэй бус Монгол улсын хувьд экологид ээлтэй хөдөө аж ахуйн эдийн засагт ч чухал ач холбогдолтой.

Бизнесээс хүний эрхийг хамгаалах төрийн үүрэг

Монгол Улсын Засгийн газраас уул уурхай, ашигт малтмалын олборлолтыг тусгайлан хөхүүлэн дэмжиж байгаатай холбоотойгоор аймаг, сумдад том, бага, гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай олон уурхайн олборлолтууд хийгдэж байна. Уул уурхайн салбарыг дунд хугацаанд хөгжүүлэх стратегийн зорилт нь Монголын эдийн засгийг өрсөлдөх чадвартай, чадварлаг



хүний нөөц бүхий уул уурхайн салбарыг эрчимтэй хөгжүүлэхэд оршиж байна.

Хүний эрхийг хамгаалах үүргээ биелүүлэхийн тулд төрөөс дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Аж ахуй нэгж, байгууллагуудыг хүний эрхийг хүндэлдэг байхыг шаарддаг хүчин төгөлдөр хуулиудыг албадан хэрэгжүүлэх, төсөөтэй хуулиуд хэрэгжиж буй эсэхийг тогтмол үнэлж, хуулийн хийдэл байгаа эсэхэд анхаарал хандуулж ажиллах;

- Компанийн тухай хууль болон бусад аж ахуй нэгж, байгууллагуудыг үүсгэн байгуулах, тэдгээрийн бизнесийн үйл ажиллагааг зохицуулдаг хууль, бодлого нь бизнесийн зүгээс хүний эрхийг хүндэлдэг байхыг хязгаарлах бус харин хүндэлдэг байх бололцоо олгож байгаа эсэхийг тодорхойлох;

- Аж ахуй нэгж, байгууллагуудад өөрсдийн бизнесийн үйл ажиллагааныхаа туршид хүний эрхийг хэрхэн дээдлэх талаар үр дүнтэй зааварчилгаа өгөх;

- Аж ахуй нэгж, байгууллагууд хүний эрхийн нөлөөлөлд анхаарал хандуулж байгаад нь дэмжлэг үзүүлэх, шаардах;

Аж ахуй нэгжийн хүний эрхийг хүндэтгэх, дэмжих үүрэг

Нөгөөтэйгүүр бизнесийн салбарынхан иргэдэд хор хохирол учруулахаас зайлсхийж, үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ авч хүний эрхийг хүндэтгэх үүрэг хүлээх ёстой.

Аж ахуй нэгж, байгууллагуудаас хүний эрхийг хүндлэх үүрэг нь тэдгээрийн хэмжээ, бизнесийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн хэлбэр, бүтэц зохион байгуулалтаас үл хамааран бүгдэд нь адил хамаарна.

Хүний эрхийг хүндлэх үүргээ биелүүлэхийн тулд аж ахуй нэгж, байгууллагуудаас дараах зүйлсийг биелүүлэхийг шаарддаг. Үүнд:

- Өөрсдийн бизнесийн үйл ажиллагааны явцад хүний эрх зөрчих, эсвэл хүний эрх зөрчихөд дам нөлөө үзүүлэхээс зайлсхийх, хүний эрхийн сөрөг нөлөөлөл үүссэн тохиолдолд түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ авах;

- Өөрсдийн бизнесийн үйл ажиллагаагаараа хүний эрхийн сөрөг нөлөөлөл үүсэхэд дам нөлөө үзүүлээгүй ч бизнесийн түншүүдийн үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээнээс шууд үүдэлтэй үүссэн хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эсвэл уг зөрчлийн нөлөөллийг бууруулах, арилгахын тулд хүчин чармайлт гаргах.



Хариуцлагатай уул уурхайн олон чухал бүрдэл хэсгүүд уг салбар, төр, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлээс хамааралтай боловч дараах дөрвөн чиглэл нь хариуцлагатай уул уурхайг тодорхойлогч цөм нь болдог юм.

Үүнд:

- Тухайн нутгийн байгаль экологи, түүх соёлын өвийг хадгалах шаардлагыг ойлгох

- Байгаль орчинд ээлтэй уурхайн ашиглалтыг хэрэгжүүлэх

- Уурхайг ашиглах нь ажилчид болон уурхайн бүсэд харьяалагдах ард иргэдэд эерэгээр нөлөөлөх

- Засаглалын зохистой бүтэцтэй байх.

Иргэний оролцооны эрх

Гэвч уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор ашигт малтмал эрэх, хайх, олборлох, зам тавих, барилга байгууламж барих

явцдаа хуулсан хөрс, овоолсон шороо, бий болгосон далан, цооног, суваг, шуудууг хэвийн байдалд нь оруулахгүй орхисноос байгалийн унаган төрх алдагдаж доройтох, улмаар хүн, мал, ан амьтан осолдож, гэмтэх, дайжих эрсдэлд хүргэж байна.

Уул уурхайн салбарын бүхий л мөчлөгт /хайгуул, олборлолт, хаалт, баяжуулах, тээвэрлэх, засаглал гм/ иргэд, олон нийтийн оролцоо гэдэг нь дараах таван цогц үйл ажиллагаа бүрэн хангагдсан байхыг ойлгоно. Эдгээрийн аль нэг байхгүй бол иргэдийн оролцоо бүрэн биш гэж үзнэ.

i. Үнэн зөв мэдээлэл авах, бодит, цаг үеэ олсон, хэрэгтэй мэдээллээр хангагдах эрх

ii. Олж авсан мэдээлэл дээрээ зөвлөлдөх оролцоо, Үзэл бодлоо илэрхийлэх, санал хэлэх, шийдвэрт саналаа тусгах

iii. Иргэд өөрийн оролцож



гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд бүтээлч идэвхтэй оролцох, хамтран ажиллах оролцоо

iv. Хяналт мониторинг хийх

v. Гомдол гаргах замаар эрхээ сэргээлгэх эрхийг цогцоор нь ойлгоно.

Хэрэв малчин танд дараах асуудлууд тулгарч байвал

Хэрэв хүн ам төвлөрсөн суурингуудын дэргэд уул уурхайн үйл ажиллагаа явуулснаас хөрс бохирдож тоосжилт ихээр үүссэнээс улбаалан таны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа бол энэ нь таны *эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг*;

Хэрэв голын гольдрол, эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд уурхайн үйл ажиллагаа явуулж тухайн голд ашигт малтмалаа угаасан усаа нийлүүлж байгаа нь хүн, мал, амьтны ундны ус бохирдох, хомстох нөхцөл бүрдсэн бол энэ нь таны *усаар хангагдах эрхийг*;

Хэрэв ил аргаар уул уурхайн үйл ажиллагаа явуулахад байгалийн унаган төрхийг алдагдуулж байгаа нь ургамал, хөрсний бүтцэд өөрчлөлт орж тухайн талбайд ургаж байсан ургамал, амьдарч байсан амьтдын төрөл зүйл устаж үгүй болгож байгаа бол энэ нь таны *орчны бохирдол, байгаль орчны тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг*;

..... уул уурхайн буруутай үйл ажиллагаанаас үүдэн дээрх эрхүүдийг зөрчөөд зогсохгүй цаашилбал таны *амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах* зэрэг олон

эрхүүд зөрчигдөж байна.

Таны эрхийг зөрчсөн дээрх асуудлууд гарсан тохиолдолд та *гомдол гаргах, төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх, зөрчигдсэн эрхээ бүрэн сэргээх, шударга шүүхээр шүүлгэх, өөрөө өөрийгөө өмгөөлөх өмгөөлүүлэх эрхтэй* байдаг.

Хүний эрхийн олон улсын хуулийн дагуу, эрх нь зөрчигдсэн хэн ч эрхээ үр нөлөөтэйгээр сэргээлгэх эрхтэй. Эрхээ сэргээлгэх гэдэг нь компанийн үйл ажиллагаанаас үүдсэн хүний эрхийн зөрчлийг арилгах арга хэмжээ болон хүний эрхийн зөрчлийг бий болгосон компаниудад хариуцлага тооцох зэрэг төрөөс авах арга хэмжээг аль алиныг нь хамруулна. Холбогдох компани нь өөрсдөө сөрөг нөлөөлөл үзүүлсэн эсвэл сөрөг нөлөөлөл үүсэхэд дэм болсон гэдгээ тогтоосон бол хууль ёсны үйл ажиллагааны дагуу зөрчсөн эрхийг сэргээх арга хэмжээ авах, эсвэл зөрчсөн эрхийг сэргээхэд хамтран ажиллах хэрэгтэй.

Уул уурхайн салбарын нөлөөгөөр газар зүйн байршлаас үл хамааран байгаль орчин, нийгмийн бүтцэд өөрчлөлт ордог. Энэ нь мөн тухайн газар нутгийн байгалийн тогтоц, ард иргэдийнх нь амьжиргаанд нөлөөлнө. Харамсалтай нь олборлолт хийж буй дийлэнх компаниудын хайгуул хийх, олборлолт явуулах процесс нь иргэдэд ил тод биш, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийн үнэлгээнүүдийг хийхдээ иргэдийг хангалттай төвшинд

ОРОЛЦУУЛЖ хийгээгүйгээс олон мянган малчин иргэд, хохирч байна.

“Монгол Улсын Үндсэн хууль”-д хүний эрх, эрх чөлөөг хуульчилсан бөгөөд тэдгээр нь хамгаалуулах эрх, үйлчлүүлэх эрх, ОРОЛЦООНЫ ЭРХ-ээр илэрдэг.

“Монгол Улсын Үндсэн хууль”-д “Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд ОРОЛЦОЖ, сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” хэмээн баталгаажуулсан байдаг.

Иргэний оролцох эрх нь хөгжих эрхийн суурь үндэс бөгөөд бусад эрхтэй нягт холбоотой. Өөрөөр хэлбэл, иргэн хүссэн үйл ажиллагаандаа оролцох замаар хөгжих боломжтой бөгөөд ингэж оролцох нь ялгаварлан гадуурхалтаас ангид байх,

албадлагын бус байх, тэгш хүртээмжтэй байх зэрэг бусад эрхийн хэрэгжилтийг шаарддаг.

Эрхээ хамгаалуулахад иргэд, олон нийтийн өөрсдийнх нь оролцоо нэн чухал. Гэвч үүнийг зөвхөн сонгох, сонгогдох, нам улс төрийн үйл ажиллагаа явуулах, жагсаал цуглаан хийх зэргээр хязгаарлан ойлгож болохгүй. Иргэд, олон нийтийн оролцоо нь эрхээ хамгаалах, өөрийн болон гэр бүл, нийгэм, нутгийнхаа хөгжлийг тодорхойлоход мэдээллээр урьдчилан хангагдах, санал бодлоо хараат бусаар илэрхийлэх, бодлогод тусгуулах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ/мониторинг/ хийх, хариуцлага шаардах, гомдол гаргаж шийдвэрлүүлэх зэрэг тасралтгүй үргэлжлэх үйл явц юм.



*Монгол Улсын Үндсэн хууль 6-р зүйлийн 6.2 дахь хэсэг:
“Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй”*

Иргэн тухайн үйл ажиллагаанд оролцохын тулд бүрэн мэдээллийг авах, бодитой мэдээллээр хангагдах шаардлагатай. Мэдээлэл хангалттай авсан бол оролцоо нь мөн адил үр ашигтай, бүтээлч байдаг. Ажиглах оролцоо нь мэдээлэл авахад голчлон чиглэдэг бөгөөд иргэдийн оролцооны эхний алхам юм. Иргэд энэ шатанд зөв мэдээлэл авч, оновчтой чиглэл байр суурийг олж авснаар цаашид идэвхтэй оролцох боломж бүрдэнэ.

Иргэний оролцоо нь нийцтэй болон нийцгүй аль ч хэлбэрээр илэрч болно. Нийцтэй оролцоо гэдэг нь тухайн бодлого, үйл ажиллагаа, системийг дэмжсэн шинжтэй байдаг бол нийцгүй оролцоо гэдэг нь үүний эсрэг юм. Иргэний оролцоо нь ажиглах оролцооноос эхлэх бөгөөд

улмаар мэдээлэл солилцох, зөвлөх, биечлэн, хийх зэргээр идэвхэждэг. Зөвлөх болон биечлэн оролцох явдлыг илүү бүтээлч оролцоо гэж үздэг. Мөн төрийн болон орон нутгийн бодлого, шийдвэр батлагдан гарахаас өмнө иргэд өөрсдийн үзэл бодлоо түүнд тусгуулах, шийдвэрт нөлөөлөхийг оролдох нь үр ашигтай оролцоо юм.

Төрийн бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хянах зэрэг бүхий л үйл ажиллагаанд иргэдийн оролцоо яагаад чухал вэ?

- Иргэд нь өөрсдийн орон нутгийнхаа хөгжлийг хамтдаа тодорхойлох, өөрсдөдөө хамааралтай асуудлыг шийдвэрлэхэд оролцох эрх бүхий хүмүүс юм.

- Иргэд төрж өссөн болон амьдарч буй орон нутгийнхаа онцлог, үүссэн нөхцөл байдал, нийтлэг ашиг сонирхол, хэрэгцээ, шийдвэрлэх шаардлагатай



тулгамдсан асуудлуудыг хамгийн сайн мэддэг.

- Иргэд орон нутгийнхаа хөгжлийн тулгамдсан асуудал, тэргүүлэх чиглэл, бодлого, хөтөлбөрийг тодорхойлох, түүнийг хэрхэн хангах тухай оновчтой арга замыг томъёолж чаддаг. Тиймээс иргэн таны оролцоо хамгийн чухал.

Хэрэв дараах байршлуудад уул уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаа бол...

- *Голын эх түүний ай сав газар, голоос хоёр тийш 150м зайд*
- *Ойн сав бүхий газар ойгоос 150 м зайд*
- *Отор, бэлчээр, хадлан зэрэг нөөцөд авсан талбай* зэрэг нь ашиглалтын тусгай зөвшөөрөл

олгохыг хориглосон талбайд хамаардаг.

Иймээс та дээрх хориглосон байршлуудад үйл ажиллагаа явуулж байгааг мэдсэн тохиолдолд иргэний оролцооны эрхээ эдэлж, холбогдох байгууллагуудад мэдээлж, өөрийн болон бусдын үндсэн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх боломжтой.

Төрийн зүгээс иргэний оролцоо эрхийг дэмжсэнээр тогтвортой хамтын ажиллагааг бий болгох боломжтой. Иргэдийн оролцоог сайжруулснаар төр, орон нутгийн захиргаа, иргэдийн холбоо бэхжиж, харилцан ойлголцох, аливаа шийдвэрт нутаг дэвсгэрийн онцлог, иргэдийн санаа бодол тусгагдах боломж бүрдэхээс гадна гарч буй шийдвэрт иргэдээс тавих хяналт үр нөлөөтэй байх болно.



ХОЁРДУГААР БҮЛЭГ

ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Уурхайг нээж олборлолт хийж эхэлсэн цагаас тухайн газар нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд тодорхой таагүй нөлөөллүүд ажиглагдаж эхэлдэг. Ийм учраас байгаль орчны менежментийн төлөвлөгөө маш сайн төлөвлөгдөж хэрэгжиж байх шаардлагатай байдаг. Зөвхөн БОМТ гэлтгүй эрсдэл, хяналт шинжилгээний хөтөлбөр шаардлагатай юм. Компаниуд жил бүр нөхөн сэргээлт хийх боломжгүй байж болно, ялангуяа үндсэн ордод блокын дүүргэлт буюу техникийн нөхөн сэргээлт хийгддэг. Нөхөн сэргээлт нь хаалтын төлөвлөгөө амжилттай үр дүн үзүүлэх нэг л урьдач нөхцөл болдог. Түүнээс нөхөн сэргээлтийг уурхайн хаалт гэж ойлгож болохгүй. Уурхайн хаалт маш өргөн хүрээний асуудал хамардгийн нэг хэсэг нь л нөхөн сэргээлт.

Өнөөдрийн байдлаар манай улсад уурхайн хаалтын харилцааг зохицуулсан хууль тогтоомж хангалттай бус байна. Мөн уурхайн хаалтын санхүүгийн тогтолцоо байхгүй шахам байна. Ийм зохицуулалтгүйгээс олон жил ажилласан уурхайнуудын үйл ажиллагаанд алдаа, гажуудал гарч байдаг. Иймээс манай улсад уурхайн хаалтыг иж бүрэн, үлгэр жишээ хийсэн төсөл байхгүй байна.

Уурхайн хаалт нь урт удаан хугацааны төлөвлөлт бүхий үйл ажиллагаа юм. Уурхай ашиглах гэж байгаа бол хаалтын төлөвлөлтөө эрт хийх ёстой, уурхай хаагдсаны дараа тухайн газрыг ямар зориулалтаар ашиглах вэ гэдэг төсөөллөө эрт гаргах, орон нутгийн газар нутгийн ерөнхий төлөвлөгөө, тогтвортой хөгжлийн бодлогод эртнээс тусгах, тэдний санал хүсэлтийг авч хаалтын төлөвлөгөө гаргах учиртай. Тиймээс төлөвлөлтөд зориулж санхүүжилтээ байнга тооцоолж, эртнээс хуримтлуулах ёстой.

ОУ-ын туршлагыг хайж үзэхэд ихэвчлэн үндэсний хэмжээний том спортын талбай болгох, амьтны хүрээлэн болгосон жишээ байна. Ийм түвшинд хүргэхэд тухайн газар хүн, амьтан, малд аюулгүй эко систем бүрдүүлэхийн тулд эртнээс бүр анхнаасаа маш хариуцлагатай технологи ашиглах, химийн бодис, аюултай хог хаягдлаа экосистемд аюулгүйгээр утсгах, зайлуулах улмаар эрсдлийн маш сайн удирдлагатай байхыг шаарддаг.

Ийм л учраас нутгийн иргэд, өдөр тутам үйл ажиллагааг харж нөлөөллийг мэдэрч байгаа олон нийт мэдлэгтэйгээр хянаж, хариуцлага шаардаж байх хэрэг гарч байна.

2.1. УУЛ УУРХАЙН ХААЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Уул уурхайн хаалт гэж олборлолтын үйл ажиллагааг зогсоож, орчны сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, арилгах бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, улмаар тухайн нутаг дэвсгэрийг хэвийн аюулгүй нөхцөлд буцаан сэргээж хүн ам, мал амьтан амьдрах нөхцөл бүрдүүлэх ажиллагааг хэлнэ. Өөрөөр хэлбэл, уул уурхайн үйл ажиллагаа явуулсанаас бий болох бүхий л хохирлыг арилгаж, анхны

байдалд оруулж, нийгэм эдийн засгийн амьдрал хүрээлэн буй орчныг хэвийн ашиглах боломжийг бүрдүүлэх юм.

Яагаад уул уурхайн хаалтын үйл ажиллагаанд анхаарал хандуулах ёстой вэ?

Энэхүү үйл ажиллагаа нь хаалтын менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдэнэ. Уг төлөвлөгөө нь агуулга, хэрэгжилт, хяналтаас хамаарч байгаль орчин нөхөн сэргээгдэх, нутгийн иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эсэх асуудал шийдвэрлэгдэнэ.



Монполимет ХХК-ны олборлосон талбайдаа хийсэн “Ойжуулалт”-ын нөхөн сэргээлт¹



Монполимет ХХК-ны олборлосон талбайдаа хийсэн “Бэлчээрийн нөхөн сэргээлт”²

¹ <http://monpolymet.mn/nuhun-sergeelt/>

² <http://monpolymet.mn/nuhun-sergeelt/>



Орхон голын хөндий 2018 он. Архангай аймгийн Цэнхэр сумын Орхон баг.

Уул уурхайн хаалтын үйл ажиллагаа дутуу, дулимаг хийгдвэл юу болох вэ?

Уг төлөвлөгөөг дутуу, хангалтгүй боловсруулж, хэрэгжүүлсэний улмаас байгаль орчин бохирдолтой, үхмэл байдалд үлдэх ба тухайн нутаг дэвсгэрт хүмүүс амьдрах аргагүй болно.

Бид яах вэ?

Уул уурхайн хаалт нь тодорхой төлөвлөгөөний үндсэн дээр хэд хэдэн үе шаттайгаар явагддаг. Эдгээр төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажиллагаанд иргэд шууд өөрсдөө болон Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөөрөө дамжуулан оролцох боломжтой байдаг.

Дараах мэдээлэл, мэдлэгийг олж авсанаар үр дүнтэй оролцож чадна.

1. Уг төлөвлөгөө, үе шат, хийгдэх ажиллагааны талаарх ойлголттой болох;

2. Хаалтын үйл ажиллагааны мэдээллийг олж авах арга;

3. Хэнд, яаж хандахаа мэддэг байх.

Хаалтын үйл ажиллагаа нь төлөвлөх, бэлтгэл ажлыг хангах, хэрэгжүүлэх, хүлээн авах гэсэн дөрвөн үе шатаар явагдана.

2.2. ХААЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨХ ҮЕ

Хаалтын бэлтгэл үе.

Энэ үе шатанд хаалтын үйл ажиллагааг явуулах шаардлагыг хангасан тохиолдолд түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, уг төлөвлөгөөнд нөхөн сэргээлт, хаалт зэрэгт шаардагдах зардал, техник, эдийн засгийн үндэслэлийг тооцоолж, эрх бүхий байгууллагаар батлуулах үйл явц.

Уурхайг хэзээ хаах вэ?

- Тухайн ордыг олборлох боломжгүй, эдийн засгийн үр ашиггүй болохыг батлах;
- Нөөцийн үлдэгдэлгүй болох.

Хаалтын менежментийн төлөвлөгөө гэж юу вэ?

Хаалтын менежментийн төлөвлөгөө гэж хаалтын үйл ажиллагаанд уул уурхайн компаний хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон баримт бичиг.

Хаалтын менежментийн төлөвлөгөө нь олборлолт дууссаны дараа хаалт хийхдээ боловсруулдаг баримт бичиг биш. Уул уурхайн компани нь хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, тухайн ордыг ашиглах болон үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлдээ хаалтын менежментийн урьдчилсан төлөвлөлтийн талаар тусгасан байх ёстой.

Хаалтын менежментийн төлөвлөгөө нь дараах агуулгатай байна.

- Хаалтын үйл ажиллагааны тойм, зорилго, зорилт ;
- Хаалтын дараах газар ашиглалтын зориулалт;
- Барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийг буулгах, нураах, шилжүүлэх ажиллагаа;
- Хаалтын өмнө болон дараа уурхайд ажиллагсад, мөн нөлөөлөлд өртөх иргэдийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ;
- Хаалтын зардлын нийт тооцоо;
- Уул уурхайн хаалтын үе

шатны дараах газар ашиглалтын зориулалтыг орон нутгийн иргэд, Засаг дарга, газар эзэмшигчтэй зөвшилцөж, тухайн орон нутгийг хөгжүүлэх хэтийн зорилт, төлөвлөгөөнд нийцүүлэн тодорхойлсон байх.

Хаалтын менежментийн төлөвлөгөөний агуулга нь дор дурдсан шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Иргэдийг мэдээллээр хангасан байх: Тухайлбал, хаалтын менежментийн төлөвлөгөөг иргэдэд урьдчилан танилцуулж, төлөвлөгөөний боловсруулалт, гүйцэтгэлийн явцын талаарх мэдээллээр хангасан байх шаардлагатай.

- Иргэдийн оролцоог хангасан байх: Төслийн хаалтын дараах газар ашиглалтын зориулалтыг орон нутгийн иргэд, Засаг дарга, газар эзэмшигчтэй зөвшилцөж, тухайн орон нутгийг хөгжүүлэх хэтийн зорилт, төлөвлөгөөнд нийцүүлэн тодорхойлсон байх. Өөрөөр хэлбэл нутгийн иргэд уг төлөвлөгөөг боловсруулахад оролцож, санал бодлоо илэрхийлэх эрхтэй.

Хаалтын үйл ажиллагаа хийх гэж байгаа компани таныг мэдээллээр хангаагүй, оролцуулаагүй бол яах вэ?

Уул уурхайн компани нь уурхайг бүхэлд нь хаах зөвшөөрөл авахдаа хаалтын менежментийн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, Уул уурхай, хүнд

үйлдвэрийн яам болон Байгаль орчин, аялал жуучлалын яаманд хүргүүлнэ. Тус яамд нь уг төлөвлөгөө нь шаардлага хангасан, хууль тогтоомжид нийцсэн эсэхэд дүгнэлт өгөх бөгөөд шаардлагагүй тохиолдолд хүлээн авахаас татгалзаж болно.

Өөрөөр хэлбэл, хаалтын менежментийн төлөвлөгөө нь дээрх агуулга, шаардлагыг хангаагүй тохиолдолд тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөвшөөрөл олгохгүй бөгөөд дахин засварлах боломж олгоно. Дахин шаардлага хангаагүй бол уул уурхайн компаниас хаалтын ажиллагаа хийхэд шаардлагатай зардлыг гаргуулж өөр мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ. Энэхүү төлөвлөгөөний биелэлт явцын талаарх тайланг жил бүр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлнэ.

Уул уурхайн нөхөн сэргээлт гэж юу вэ?

Уурхайн олборлолт болон хаалтын явцад нутаг дэвсгэрийг эрсдлээс хамгаалах, хэвийн байдалд сэргээхэд чиглэсэн ажиллагааг уурхайн нөхөн сэргээлт гэнэ. Нөхөн сэргээлтийг хаалтын менежментийн төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлийг хангана. Зардлыг мөн төлөвлөгөөнд тусгана.

Хаалтын нөхөн сэргээлт хийхийн өмнө хаалтын менежментийн нарийвчилсан төлөвлөгөөний хүрээнд хамаарах байгаль орчны аюулгүй байдлын дараах шалгууруудыг хангасан байна:

- Уурхай орчмын үйлдвэр, уурхай, хот, суурин газарт гүний усны нэвчилт, газрын хагарал, суулт зэрэг аюултай нөлөө үүсэхгүй байх;

- Агаар, хөрс, усыг бохирдохоос хамгаалах, усны нөөц шавхагдахаас сэргийлсэн байх гэх мэт.

Хаалтын зардал гэж юу вэ? Ямар учиртай вэ?

Хаалтын зардал дараах зардлаас бүрдэнэ. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагаанаас үүсч болох болон үүссэн байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх арга хэмжээний зардал;

- Уурхайн талбайн аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагааны зардал;

- Хаалтын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал гэх мэт.

2.3. УУРХАЙН ХААЛТЫН БЭЛТГЭЛ ШАТ

Энэ үе шатанд хаалтын үйл ажиллагааны нарийвчилсэн менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулалын яам хүлээж авснаас эхлэн уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх бэлтгэл ажиллагаа хамаарна.

Бэлтгэл шатанд ямар ажиллагаануудыг хамруулан хэрэгжүүлэх вэ?

Уурхайн компани нь уурхайг бүхэлд нь хаах хүсэлтээ Уул, уурхай хүнд үйлдвэрийн яаманд гаргах бөгөөд дараах баримт бичгийг хамт хавсаргана.

- Уул уурхайн хаалтын үе шатны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг хангасан байдал;

- Уул уурхайн хаалтын үе шатны дараах хяналт-шинжилгээ, арчилгаа, тордолтыг хийх хугацаа, зарцуулах зардлын хэмжээ;

- Нөлөөлөлд өртсөн иргэдийн эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй байдлыг хэрхэн шийдвэрлэсэн байдал;

- Хаалтын дараах газар ашиглалтын зориулалт;

- Барилга байгууламж, оффис, ажилчдын байрыг нүүлгэн шилжүүлэлтийн байдал, Уул уурхайн хаалтын хүрээнд дэх бүх төрлийн зам, эрчим хүч болон дулааны шугам сүлжээ, эх үүсвэр, усан хангамжийн цогцолборыг орон нутагт хүлээлгэн өгөх, энгийн горимд шилжүүлэх байдал, ажиллагсдын нийгмийн болон цалин хөлсний асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдал гэх мэт.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам дээрх хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хаалтын бэлтгэл ажлын талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Тухайн ордын батлагдсан нөөцөд тулгуурлан олборлолт хийсэн талбайн маркшейдрын хэмжилтийг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хийлгэх;

- Нөөцийн балансын

хөдөлгөөнийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар гаргуулах;

- Үйлдвэрлэлийн үр ашиггүй нөөцийн үлдэгдлийн тооцооллыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтээр тогтоолгох;

- Уул уурхайн хаалтад зарцуулах хаалтын барьцаа хөрөнгийг зайлшгүй байршуулсан байх зэрэг.

Иргэд болон орон нутгийн удирдлага хэрхэн оролцох вэ?

Дээрх бэлтгэл ажил хангагдсаны дараа Уул уурхай, хүнд үйлдвэрийн болон Байгаль орчин, аялал жуучлалын сайдын хамтарсан тушаалаар хаалтын үйл ажиллагааг эхлүүлэх комисс байгуулна. Иргэд уг комиссийн бүрэлдэхүүнд орж, санал, бодлоо илэрхийлэх, хяналт тавих боломжтой.

Комисс нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

- Тухайн орон нутгийн байгаль орчны алба;

- Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулсан уурхай олборлогч;

- Ашигт малтмал тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавихаар иргэдээс сонгогдсон төлөөлөгч болон нутгийн иргэд;

- Төрийн бус байгууллагын төлөөлөл гэх мэт.

Уг комисс нь уурхайн төслийн хаах бэлтгэл ажлыг газар дээр нь шалгаж, тэмдэглэл хөтлөх ба тэмдэглэлд дараах зүйлсийг тусгана:

- Төслийг хаах бэлтгэл ажил хангагдсан байдал;

- Хаягдлын аж ахуйн аюулгүй байдал, техник, технологийн аюулгүй байдал;

- Ажиллагсдын нийгмийн болон цалин хөлсний асуудлыг шийдвэрлэсэн байдал;

- Нөлөөлөлд өртсөн болон өртөх иргэдийн нийгмийн, эрүүл мэнд, аюулгүй байдлыг шийдвэрлэсэн байдал гэх мэт.

Комиссын гишүүдийн олонх бэлтгэл хангагдсан гэж үзвэл хаалтын үйл ажиллагааг эхлүүлэх тухай шийдвэр гаргана. Энэ шийдвэрийг гаргаснаас хойш уурхайн үйл ажиллагаа явуулахгүй.

2.4. УУЛ УУРХАЙН ХААЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШАТ

Энэ шатанд ямар ажиллагаа хийгдэх вэ?

Дээрх комиссын шийдвэрийг үндэслэн хаалтын нарийвчилсан менежментийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ. Уул уурхайн компани нь байгаль орчин, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын талаарх мэдээллийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тогтмол хүргүүлж байна.

Хэрхэн хяналт тавих вэ?

Уурхайн хаалтын менежментийн нарийвчилсан төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын

байцаагч, бүх шатны Засаг дарга, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага хяналт тавина.

Зөрчил илэрсэн тохиолдолд хаана, хэнд хандах ёстой вэ?

Хяналтын явцад илэрсэн зөрчил зөрчил, дутагдлын талаарх өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллийг мэргэжлийн хяналтын газарт гаргаж, шийдвэрлүүлэх боломжтой.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар		
Вэб сайт:	Цахим хаяг:	Холбоо барих утас:
http://inspection.gov.mn/new/?p=3539	info@inspection.gov.mn	(+51)264786, 1800-1286

2.5. УУЛ УУРХАЙН ХААЛТ, ХААЛТЫГ ХҮЛЭЭН АВАХ ШАТ

Хэзээ хаалтыг хүлээж авах вэ?

Нарийвчилсан менежментийн төлөвлөгөөг бүхэлд нь хэрэгжүүлсэн тохиолдолд л уурхайг бүхэлд нь хаана. Гэхдээ дараах нөхцөлд уул уурхайн хаалтын үе шатыг түр болон гэнэтийн хаалтын горимд шилжүүлж болно.

- Уул уурхайн хаалтын үе шатыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэргүй болсон;

- Зах зээл дэх түүхий эдийн үнэ унасан;

- Олборлолтын явцад хайгуулаар тогтоогдсон нөөц батлагдахгүй, нэмэлт хайгуул хийх шаардлагатай болсон;

- Байгаль, экологийн тэнцвэрт байдал алдагдсан (газар хөдлөлтөөр үүссэн сүйрэл, эвдрэл, элэгдлээс суулт, гулсалт, нуралт гэх мэт);

- Байгаль орчинд аюултай, хортой нөлөөлөл үүссэн;

- Давагдашгүй хүчин зүйл тохиолдсон.

Уул уурхайн компани нь тухайн уул уурхайн хаалтын үе шатны суурь бичиг баримтын хүрээнд жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан тухайн жилийн хөндөгдсөн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж орон нутагт хүлээлгэн өгсний дараа тухайн газарт үйл ажиллагаа дахин явуулахгүй бол хэсэгчилсэн хаалтад бэлтгэж болно.

Комисс нь хаалтын менежментийн төлөвлөгөөний хяналтын дүнд үндэслэн уурхайн хаалтыг хүлээн авах, эсэхийг олонхийн саналаар шийдвэрлэж дүгнэлт гаргана. Дүгнэлтийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хүлээж авах тухай шийдвэр гаргана. Өөрөөр хэлбэл, уг комиссын бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөл, нутгийн Засаг дарга зэрэг багтаж байгаа учир тэдгээр нь төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх, байр сууриа илэрхийлэх боломжтой. Хэрвээ хаалтыг хүлээж авсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны шийдвэртэй санал нийлэхгүй бол иргэн та гомдол гаргах эрхтэй.

Хаалтыг хүлээж авснаар ямар үр дагавар үүсэх вэ?

Хаалтыг хүлээж авснаар уул уурхайн компани нь байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх болон бусад үүрэг, хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

Уурхайн компани нь комиссын шийдвэрийг үндэслэн хаалтын дараах орчны хяналт шинжилгээг хаалтын менежментийн төлөвлөгөөнд заасны дагуу гүйцэтгэнэ. Түүнчлэн хаалтын нөхөн сэргээлт хийсэн газрыг орон нутгийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөхдөө цаашид хийх хяналт-шинжилгээ, арчилгаа, тордолтын ажилд шаардагдах зардлыг тухайн орон нутгийн болон уул уурхайн хаалтыг хэрэгжүүлэгчийн хамтарсан дансанд байршуулна.

Уурхайг бүхэлд нь хаасны дараа уул уурхайн хаалтыг хэрэгжүүлэгчийн хариуцан гүйцэтгэх хяналт-шинжилгээний ажлын хөтөлбөр бүрэн хэрэгжиж дуусмагц нөхөн сэргээсэн талбайг тухайн орон нутгийн захиргаанд шилжүүлнэ. Ийнхүү хүлээлгэж өгөхдөө тухайн ажлын цар хүрээ, үр дүнг илтгэсэн тайлан, ажлын зургуудыг гаргана.

Уурхайн хаалтыг хүлээн авсан шийдвэр гарсны дараа уул уурхайн хаалтыг хэрэгжүүлэгч нь нөөцийн тайлан, ашигт малтмалын ордын геологи, маркшейдрын холбогдох зургийн эх хувийг холбогдох мэдээллийн санд хүлээлгэн өгнө.

2.6. УУРХАЙН ХААЛТ ДАХЬ ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

Уурхайн компани нь хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулахдаа уул уурхайн сөрөг нөлөөлөлд өртөх нутгийн иргэдэд танилцуулах замаар олон нийтийн оролцоог хангаж ажиллана.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуучлалын яам, уул уурхайн хаалтын үе шат хэрэгжиж буй нутгийн Засаг дарга нь мэдээллийн санд хаалтын менежментийн төлөвлөгөөнд санал өгөх, хүлээн авах зэрэг үйл явцтай холбоотой мэдээллийг тогтмол байршуулна.

Уурхайн компани нь хаалтын менежментийн төлөвлөгөөг өөрийн цахим хуудсанд байршуулна. Түүнчлэн хэрэгжилтийн талаарх мэдээллийг жилд нэгээс доошгүй удаа уул уурхайн сөрөг нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулна.

Хаалтын дараах орчны хяналт шинжилгээ, арчилгаа, тордолт.

Уурхайн компани нь хаалтын дараах орчны хяналт шинжилгээ, арчилгаа, тордолтын ажлын төлөвлөгөөнд заасан чиглэл, хугацаа, давтамжийн дагуу хаалтын дараах хяналт-шинжилгээ, арчилгаа, тордолтыг хэрэгжүүлнэ.



ГУРАВДУГААР БҮЛЭГ

БОДИТ ЖИШЭЭ

Шигтгээ 1. «Монполимет» ХХК-ийн сайн туршлага

Монполимет ХХК нь 1996 оноос Булган аймгийн Бүрэгхангай, Төв аймгийн Заамар сумын нутагт орших Баянгол, Тосонгийн дэнжийн болон гольдролын шороон ордуудад ашиглалтын үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Тус компани нөхөн сэргээлтийн үйл ажиллагаандаа:

- Байгаль хамгаалал, олборлолтыг нягт уялдуулах замаар байгалийг байнгын эзэмшил тордолт, хараа хяналттай болгож, нутгийн хүн амд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг бүрдүүлж, ISO 14001 стандартыг нэвтрүүлэн ажилладаг.

- Монгол орны экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалахад онцгой үүрэг бүхий ургамлын зүйлийг судлах, сэргээн нутагшуулах, тарималжуулах ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөж хэрэгжүүлдэг.

- Ашигт малтмалыг байгальд ээлтэй арга, технологиор ашиглахыг дэмжиж, уурхайн үйл ажиллагааны явцад эвдэрч гэмтсэн хөрсийг нөхөн сэргээх үйл ажиллагаанд ихээхэн анхаарч ажилладаг.

- Байгалийн тэнцвэрт байдал, ой, бэлчээр, тариалангийн талбайг хамгаалахын тулд хортон мэрэгч, шавьжтай тэмцэх ажлыг технологийн горимын дагуу зохион байгуулж байна.

- Орон нутгийн иргэд, олон нийтийн байгууллагын санал зөвлөмжийг өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэн ажиллахыг зорин ажилладаг.

Техникийн нөхөн сэргээлтийн үе шатууд:

1-р үе шат: Уурхайн ашиглалт эхлэхээс өмнө ургамлын нөмрөг бүрхэвч болох шимт хөрсийг хуулж тусад нь овоолгоор хадгалж нөхөн сэргээлтийн хамгийн эхний үе шатны ажил хийгдэж эхэлдэг.

2-р үе шат: Ашиглалтын үед үүссэн орон зайг дотоод овоолгоор дүүргэн “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS 5917:2008 стандартаар газрын гадаргын анхдагч хэлбэрт оруулж, тэгшлэн биологийн нөхөн сэргээлтэд бэлэн болгоно.



Биологийн нөхөн сэргээлтийн үе шатууд:

- Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулсан цагаасаа эхлэн байгаль орчноо хамгаалах, ашиглалт хийгдсэн талбайгаа унаган төрхөнд нь ойртуулан нөхөн сэргээлтийн ажлыг жил бүрийн БОМТ-дөө тусгаж хийхийг чухалчилан үзэж олборлолт явуулж нөөц дууссан талбайдаа тухай бүрт нь ХААЛТ-ын арга хэмжээг хэрэгжүүлэх бодлого хэрэгжүүлдэг.

- Ашиглалт олборлолт хийсэн бүх талбайдаа 100% техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг БОМТ-ний график төлөвлөгөөний дагуу тусгайлан хөрөнгө, хүч гарган мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэдэг.

- Нөхөн сэргээлт, Хаалтын ажил хийхэд олборлолт хийх явцад ашиглах тоног төхөөрөмж, технологи нь байгаль орчинд сөрөг нөлөө хамгийн бага байх сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглах, цаг ямагт экологийн баримжаатай бодлогыг хэрэгжүүлэн ажилладаг.

Тосон уурхайн биологийн нөхөн сэргээлт ургамалжуулалтын ажлын нэг үндсэн чиглэл нь Тосонгийн ордын суналтын дагуу модны ногоон төгөл байгуулах буюу ойжуулах ажил юм. Одоогийн байдлаар тус уурхайд ойжуулалтын ажлаар нийт 5,5 км урттай 5 хэсэг ойн төгөлийг байгуулаад байна. Үүнд улиас, хайлаас, бургас, чацаргана, үхрийн нүд, торлог зэрэг нийт 60000 гаруй модыг тарьж ургуулан арчилж байна.



Шигтгээ 2. ХОБОМ –ХАМТЫН ОРОЛЦООТОЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ МОНИТОРИНГ

“Хил хязгааргүй алхам төв” ТББ нь 2020-2021 онд НҮБ-ын “Байгаль орчны засаглал” төслийн дэмжлэгтэйгээр “Хамтын оролцоотой байгаль орчны мониторинг” хийх аргачлал боловсруулж уул Төв аймгийн Баянжаргалан сум болон бусад 2 суманд туршиж байна.


Байгалийн баялаг алт, нүүрс, жонш, төмөр гээд баялгууд ургаж нэмэгдэхгүй нэг л удаагийн нөөц юм. Энэ утгаараа уурхайн олборлох төсөл хэзээ нэг цагт дуусдаг. Нөөц дуусах эсхүл алт, нүүрс, жонш, төмөр зэргийн зах зээл дэх үнэ бууж зардлаа нөхөхгүй үед түүнийг олборлох ажил зогсдог. Өөрөөр хэлбэл уурхай хэдийд ч хаагдаж болно гэсэн үг.

Иймд уурхай зогсох буюу хаагдсаны дараа компани техникээ аваад явна. Харин нутгийн иргэд

тэндээ л амьдарна, амьдрал үргэлжилнэ. Иймд нутгийн иргэд анхнаасаа ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны үе шат болгонд хяналт тавьж, оролцох эрхээ хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Жил бүрийн БОМТ –ний хэрэгжилтийг нутгийн иргэдэд танилцуулж тайлагнаж байх үүрэг компаниудад бий. Харин энэ танилцуулсан мэдээлэл үнэн үү, бодитой юу, БОМТ-г амжилттай хэрэгжүүлсэн үү гэдгийг тэр бүр иргэд мэддэггүй.

Харин ХОБОМ хийж сурснаар “баримтыг хамтдаа олж тогтоох” замаар иргэд, нөлөөллийн бүсийн малчид тогтмол, урт хугацаанд байгаль орчны өөрчлөлтийг хэмжиж, тусгай зөвшөөрөл эзэмшиж, үйл ажиллагаа явуулж буй компанийг хариуцлагатай ажиллуулах боломжтой болох юм. ХОБОМ гарын авлагыг <https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/цахим> сайтаас үзэх боломжтой.



ХОБОМ хийх алхамууд



Төв аймгийн Баянжаргалан сумын туршлага.

Төв аймгийн Баянжаргалан сум нь МУ-ын төв хэсэгт, говь хээрийн бүсэд оршдог бөгөөд тус суманд нүүрсний зургаан орд байдаг. Тэдгээрээс хоёр компанийн нүүрс олборлолтын үйл ажиллагаа зөрчилтэй байгааг олж тогтоосон. Тухайлбал, “А” ХХК 2020 онд үйл ажиллагаагаа явуулаагүй. Харин 2017 оны намраас эхлэн “Б” ХХК-ны олборлолтоос шүүрлийн ус төлөвлөж байснаас их хэмжээгээр

гарсан. Усны далан байгуулах, шүүрлийн усыг дахин ашиглах, аж ахуйн зориулалтаар ашиглах талаар төлөвлөх шаардлага гарсан ч энэ төлөвлөлт бие даасан төсөл болох учир БОННУ хийлгэх ажил удаан байсан байна.

Нүүрсний олборлолтоос гүний шүүрлийн ус ил задгай асгарч, 25км урт, 2км өргөн талбайг хамарсан өргөн хүрээтэй шавар шалбааг бий болгосон. Энэ талаар талуудын байр суурь:

	Байгаль орчинд:	Нийгэмд:	Эдийн засагт:
Иргэд олон нийтийн байр суурь	Гүний ус их хэмжээгээр шүүрч байгаа тул хээрийн бүсэд байгаа бусад худгийн усны түвшин багасах эрсдэлтэй. Их хэмжээний бэлчээрийн талбай хамарсан шавар шалбааг хавар намартаа бэлчээрийг хомсдуулж байгаа.	Малчдын мал шаварт унах, шигдэх тохиолдол гардаг, шавартай талбайг тойрч сум орох болдог тул малчид илүү цаг зарцуулах, илүү шатахуун зарцуулах болдог.	Малчин өрхийн мал шаварт үхэх, шавраас холуур бэлчээрлүүлэхэд их хүн цаг зарцуулах, аймаг сум орж төрийн үйлчилгээ авахад тойруу замаар явж, илүү шатахуун зарцуулж байгаа асуудлаар удаа дараа сумын ЗДТГ, ИТХ-д хандсан ч арга хэмжээ авч чадаагүй байна.
Компаний байр суурь	Буруутай гэдгээ хүлээн зөвшөөрнө. Гэхдээ бэлчээрийн талбайд чийг өгч байгаа. Их талбайг хамарсан нь үнэн гэхдээ хур тунадас багатай нутагт хөрс, ургамлын эвдрэлд нөлөөлөл үзүүлээгүй, харин ч чийг өгч тэжээж байгаа.	Ил задгай ус гарсанаар хавар чийг дагаж эрт ногоо гардаг. Харин ч мал эрт ногоо идэх боломжийг олгож байгаа тул хавар мал эрт ногоо идэж байна.	Компани далан байгуулах талаар төсөл, үнэлгээ боловсруулж зардал гаргаж байна. Харин ил гарч буй усаар Баян, Баянжаргалан сумд тэжээлийн ургамал тариалах, газар тариалан хөгжүүлэх зэрэг эдийн засгийн үр ашигтай болгох боломж бий. Гэтэл нутгийн захиргааны бодлого байр суурь тодорхойгүй, ойлголцох уулзалт хийгдэхгүй байна.
Нутгийн захиргааны байр суурь	Манай сум БО-ны улсын байцаагч байхгүй. Манай суманд олборлолт хийгддэггүй, харин шүүрлийн ус байдаг. Шүүрлийн усан дээр БОМТ-д өөр заагдсан үүрэг байхгүй гэж ойлгосон. Бидэнд мэргэжлийн хүн байхгүй учир аймгийн МХГ-т хандсан ч үр дүн гараагүй байна.	Манай сумын малчид, иргэдээс удаа дараа гомдол, санал ирж байсан. Багийн ИНХ дээр яригддаг асуудал. Гэвч манай сумын нутагт лиценз нь байдаггүй тул нүүр тулсан уулзалт хийж байгаагүй. БО улсын байцаагч газар дээр нь үзлэг хийх талаар санал боловсруулж байна.	Нутгийн малчидтайгаа очиж уулзахын тулд тойрч явахаас өөр арга байхгүй болсон нь илүү зардал гаргаж, зарим айлд очиж чадахгүй байдал үүсгэж байсан. Хэрлэн голын сав хүртэл задгай ус урссан байсан. Энэ үнэн. Удаа дараа иргэдээс санал гомдол ирдэг нь төрийн ажлын ачааллыг нэмэгдүүлдэг.

Ийм учраас зөвлөлдөх уулзалтаар “Б” ХХК-ийн удирдлагатай уулзаж, байгаль орчны хэлтэс, түүний төлөөлөл мэргэжилтэн, байгаль орчны аудитын төлөөлөл төслийн талаар мэдээлэл хийсэн.

Зөвлөлдөх уулзалтаар олж тогтоосон асуудал:

- Нүүрс олборлолтын явцад гүний ус төсөөлж байснаас хэт ихээр гарсан учир хоолойгоор татаж, гадагш урсгахаас аргагүй байдалд хүрсэн.

- Усны шүүрэл багасахгүй байгаа учраас 2020 оны 8 сараас усны далан байгуулах төсөл боловсруулж БОННУ хийгдэж байгааг олж тогтоосон.

- Гүний усны шүүрлийн улмаас хөрсний шимт байдал, бэлчээрийн ургамлын тоо, чанар, ахуйн хэрэглээний худгийн усны түвшинд үзүүлж байгаа нөлөөллийн эрчимд ХОБОМ хийх

- Нүүр тулсан уулзалт хийж талууд ойлголцож, ярилцаж хамтдаа шийдэл хайж байх нь чухал үйл явц гэдгийг талууд хүлээн зөвшөөрсөн.

- Шүүрлийн гүний усыг газар тариалан, тэжээлийн ургамал зэрэг эдийн засгийн үр ашигтай эргэлтэд оруулахад нутгийн захиргаа бодлого гаргах боломжийг судлахаар болсон.

“Б” ХХК-ны үйл ажиллагаатай холбоотой ХОБОМ хийсэн мэдээлэл:

ХОБОМ хийх асуудлууд	ХОБОМ цэг болон хяналт хийсэн тоо	ХОБОМ харьцуулсан хяналтын цэгийн тоо	Нийт хяналтын цэг
Хөрс	4/1 намар	2/1 намар	6
Ургамал	3/1 намар	1/1 намар	4
Худгийн ус	4/1 намар	2/1 намар	6
ДҮН			16

Баянжаргалан сумын ХОБОМ-ын багт сумын төвийн иргэд, уурхайн нөлөөллийн бүсийн иргэд, захиргаа, компаний төлөөлөл тэнцүү оролцоотой ажилласан болно. Цаашид 3 жил, түүнээс цааш тогтвортой, тогтмол хугацаанд “баримтыг хамтдаа олж тогтоох” мониторингийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АШИГТ МАЛТМАЛЫН ХААЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУД

4.1. Олборлох салбарын хууль тогтоомжууд

Хуулийн нэр	Холбогдох зүйл, заалт	Ач холбогдол
Ашигт малтмалын тухай хууль 2006.07.08	<p>45 дугаар зүйл. Уурхайг хаах үед тавигдах шаардлага</p> <p>- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаах бол Уул уурхай хүнд үйлдвэрийн яаманд нэгээс доошгүй жилийн өмнө мэдэгдэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хамтран баталсан уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын дагуу зохих бэлтгэлийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:</p> <p>-уурхайн талбайг нийтийн зориулалтаар ашиглахад аюулгүй болгох, байгаль орчныг нөхөн сэргээх талаар холбогдох арга хэмжээг бүрэн авах;</p> <p>-уурхайн эдэлбэр байсан газрыг нийтийн зориулалтаар ашиглахад аюул учирч болзошгүй бол түүнээс сэргийлэх арга хэмжээ авах;</p> <p>-тухайн нутгийн захиргааны байгууллага, эсхүл мэргэжлийн хяналтын албанаас талбайд үлдээхийг зөвшөөрснөөс бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд хөрөнгийг талбайгаас гаргах.</p> <p>- Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас үүсч бий болсон, аюул учруулж болзошгүй газруудыг зохих масштабын газрын зураг дээр нарийвчлан тэмдэглэж, шаардлагатай тэмдэг, дохио, сануулгыг уурхайн эдэлбэрийн орчинд байрлуулах бөгөөд газрын зургийг мэргэжлийн хяналтын алба болон тухайн сум, баг, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгнө.</p>	<p>Уурхайг хаах үед эдгээр шаардлагыг хангасан байх ёстой. Иргэд эдгээр хэм хэмжээг мэдсэнээр уурхайг хаах ажиллагаа нь хуулийн дагуу явагдсан эсэхэд дүгнэлт өгөх боломжтой болно.</p>

	<p>53 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл дуусгавар болох үндэслэл</p> <p>- Тусгай зөвшөөрөл дуусгавар болсноор тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уурхайг хаах талаар Ашигт малтмалын тухай хуульд заасан Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг, Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг, Уурхайг хаах үед тавигдах шаардлага болон байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу хүлээх үүргээс чөлөөлөгдөхгүй.</p>	<p>Энэхүү заалтад үндэслэн тусгай зөвшөөрөл эзэмшигчээс Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.</p>
	<p>54 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан өгөх</p> <p>- Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Ашигт малтмал, газрын тосны газрын баталсан маягтын дагуу өргөдөл үйлдэж тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг өөрийн хүсэлтээр бүхэлд нь буцаан өгч болно.</p> <p>- Талбайг бүхэлд нь буцаан өгөх тухай өргөдөлд байгаль орчныг хамгаалах, мэдээ, тайлан гаргах зэрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг болон уурхайг хаах үед тавигдах шаардлагыг биелүүлснийг нотлох баримтыг хавсаргана.</p> <p>-Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан өгөх тухай өргөдлийг хүлээн авсан даруйд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайг хаах үед тавигдах шаардлагыг хангасан эсэхийг хянаж түүнийг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэж, зохих өөрчлөлт оруулна.</p> <p>- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан өгсний дараа тусгай зөвшөөрлийг Ашигт малтмал, газрын тосны газарт буцааж өгнө.</p> <p>- Ашигт малтмал, газрын тосны газар нь тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан авсан тухай зохих байгууллагад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.</p> <p>- Тусгай зөвшөөрөл эзэмшигч талбайг бүхэлд нь буцаан өгснөөс хойш 2 жилийн хугацаанд тус талбайд дахин өргөдөл гаргах эрхгүй.</p>	<p>Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг буцаан өгөхтэй холбоотой харилцаа хуулийн дагуу явагдсан эсэхийг хянах боломжтой.</p>
	<p>27 дугаар зүйл. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг</p> <p>-Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:</p> <p>-геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад байгаль орчин, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын асуудлаар тогтмол мэдээлэх үүрэг бүхий ажилтантай байх;</p>	

<p>Цөмийн энергийн тухай хууль, 2019.07.16</p>	<p>27 дугаар зүйл. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг</p> <p>- Тусгай зөвшөөрөл дуусгавар болсноор тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу хүлээх үүргээс чөлөөлөгдөхгүй.</p> <p>- Тусгай зөвшөөрөл дуусгавар болоход түүнийг эзэмшиж байсан этгээд тусгай зөвшөөрлийг тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад буцааж өгнө.</p>	<p>Уг хэм хэмжээг үндэслэн байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан үүргээ биелүүлэхийг шаардах боломжтой.</p>
<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 2012.05.17</p>	<p>8 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ</p> <p>- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд дараах асуудлыг тусгана:</p> <p>-газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт зэрэг төсөлдхаалтын үйл ажиллагааны чиглэл, нөхөн сэргээлтийн зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд, дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ;</p> <p>9 дүгээр зүйл. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө</p> <p>- Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчин, аялал жуулчлалын яамны нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ.</p> <p>- Төсөл хэрэгжүүлэгчийн нөлөөллийн үнэлгээгээр тавигдсан шаардлага болон уурхайн ашиглалтын жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулсан хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу уурхайн хаалтын үе шатанд буцаан олгоно.</p> <p>- Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, байгаль орчин, аялал жуулчлалын яам болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина.</p>	

4.2. Байгаль орчны салбарын багц хууль тогтоомжууд

Хуулийн нэр	Зүйл заалт	Ач холбогдол
<p>Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995.03.30</p>	<p>20 дугаар зүйл. Байгаль орчны чадавхийн хэм хэмжээ - Байгаль орчны чадавхийн тогтоосон хэм хэмжээг хэтрүүлэн байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчинд учруулсан хохирлыг өөрөө арилгах буюу мэргэжлийн байгууллагаар арилгуулж гарсан зардлыг нөхөн төлнө.</p> <p>21 дүгээр зүйл. Байгаль орчныг бохирдохоос хамгаалах - Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулахгүй байх талаар дараахь үүрэгтэй: -хортой, аюултай бодис болон хог хаягдлыг гагцхүү тусгайлан тогтоосон зориулалтын газар зөвшөөрөгдсөн аргаар булаах, устгах; -хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тусгайлан тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаях; -оршин суугаа /оршин байгаа/ орчноо болон нүүхдээ бууцаа цэвэрлэж, шаардлагатай бол ариутгаж байх; -хашаа, байрныхаа орчны хог хаягдлыг тогтмол цэвэрлэх. - Цацраг идэвхт болон химийн хортой, аюултай бодис, тэдгээрийг агуулсан нэгдлийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмыг хуулиар, үйлдвэрлэл, ахуйн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хоргүйжүүлэх, халдваргүйжүүлэх, боловсруулах, булаах, устгах журмыг Засгийн газар тус тус тогтооно.</p> <p>25 дугаар зүйл. Байгалийн баялгийг нөхөн сэргээх - Байгалийн баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчны тэнцлийг хангах зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: -байгалийн баялаг ашигласан газар, орчныг засаж сайжруулах, тохижуулах.</p>	

<p>Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай 2009.07.16</p>	<p>4 дүгээр зүйл.Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлахдаа уг тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор төлөх бөгөөд холбогдох журмыг Засгийн газар тогтооно.</p> <p>5 дугаар зүйл.Байгаль орчныг нөхөн сэргээх - Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцалсан нь тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийг байгаль орчныг нөхөн сэргээх үүргээс чөлөөлөхгүй. - Байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг орон нутгийн удирдлага болон нутгийн иргэдийн олон нийтийн хяналт дор 2 хүртэл жилийн хугацаанд хийж дуусгана.</p>	
<p>Ургамал хамгааллын тухай хууль 2007.11.15</p>		<p>Олборлолт хаагдсан болон хаягдаж орхигдсон үед эхлэхийн өмнө буюу эрх авахын өмнө ургамалыг хэрхэн хамгаалах зохицуулах талаар хуульчлан өгөөгүй байна.</p>
<p>Амьтны тухай хууль 2012.05.17</p>		<p>Олборлолт хаагдсан болон хаягдаж орхигдсон үед амьтны талаар хэрхэн зохицуулах талаар хуульчлан зохицуулж өгөөгүй байна</p>
<p>Газрын хэвлийн тухай хууль 1988.11.29</p>	<p>20 дугаар зүйл.Газрын хэвлийг ашиглагчийн үндсэн эрх, үүрэг - Газрын хэвлийг ашиглагч нь дор дурдсан шаардлагыг хангах үүрэгтэй: -газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож, цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулан анх зөвшөөрөл олгосон нутгийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх;</p>	
	<p>31 дүгээр зүйл.Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглах журам - Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчныг бохирдуулсан, түүний баялгийг зүй бусаар ашигласан, гэмтээж сүйтгэсэн зэргээс учирсан хохирлыг арилгах үүрэгтэй.</p>	

<p style="text-align: center;">Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль 2012.05.17</p>	<p>6 дугаар зүйл.Төлбөр тооцох үзүүлэлт</p> <p>- Ус бохирдуулсны төлбөр тооцох үзүүлэлтийг дараах байдлаар тогтооно:</p> <p>-хоногт 50 шоометрээс их хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчийн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг килограммаар;</p> <p>-хоногт 50 шоометрээс бага хаягдал ус гаргадаг үйлдвэр, үйлчилгээний нэгж, хүн амын ахуйн хэрэглээнээс гарах хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисыг жишиг хэмжээгээр үнэлэн килограммаар;</p> <p>-хаягдал усан дахь аюултай бохирдуулах бодисын хэмжээг граммаар.</p> <p>- Хоногт 50 шоометрээс бага, аюултай бохирдуулах бодис агуулаагүй хаягдал ус гаргадаг үйлдвэр, үйлчилгээний нэгжээс гарах хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг үйлдвэр, үйлчилгээний салбар бүрээр усны хэрэглээний норм, хүчин чадал, ашиглалтын горимыг үндэслэн байгаль орчин, аялал жуулчлалын яам хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтооно.</p>	
--	---	--



**Байгаль
орчныг
хамгаалах
тухай хууль
1995.03.30**

31 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

- Аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь үүрэгтэй байна:

-байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын шийдвэр, улсын байцаагч, байгаль хамгаалагчийн шаардлагыг биелүүлэх;
-эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны холбогдолтой стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг чанд сахин биелүүлж, дотоодын хяналтыг хэрэгжүүлэх;

-үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх явцад байгаль орчинд гаргаж байгаа хорт бодис, физикийн хортой нөлөөлөл, хог хаягдлын хэмжээг бүртгэж, тэдгээрийг багасгах, цэвэрлэх талаар авсан арга хэмжээ, хянах төхөөрөмжийн ажиллагааны тухай тайлан мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад өгөх;

-байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх;

-бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байх.

-хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдийн байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хариуцлага хүлээлгэхийг Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагчаас шаардах;

-өөрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг арилгах, холбогдох байгууллагад мэдэгдэх, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн ногдуулсан нөхөн төлбөрийг ажлын 14 хоногт багтаан төлөх;

4.3. Өргөдөл, гомдол гаргахтай холбоотой хууль, тогтоомж

Хуулийн нэр		Ач холбогдол
<p>Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995.03.30</p>	<p>4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг - Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахыг эрхийг эдэлнэ: - Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах, байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах</p> <p>57 дүгээр зүйл. Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хууль бус үйл ажиллагаагаараа байгаль орчин, түүний баялагт учруулсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй. - Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас байгаль орчны алдагдсан тэнцлийг болон байгалийн баялгийг нөхөн сэргээх, хүн амыг нүүлгэх, мал, амьтныг тухайн нутаг дэвсгэрээс шилжүүлэхэд гарсан зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр сум, дүүргийн Засаг дарга шүүхэд нэхэмжлэл гаргана. - Гэм буруутай этгээд дээрх хохирлыг нөхөн төлсөн нь түүнд зохих хууль тогтоомжийн дагуу Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.</p> <p>58 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага - Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p>	<p>Уул уурхайн сөрөг нөлөөллийн улмаас учруулсан хохирол, хариуцлагыг нэхэх, нийтийн / иргэд, ард түмний / ашиг сонирхлыг хамгаалахаар шүүхэд хандах эрхийг олгосон.</p> <p>Уул уурхайн үйл ажиллагааны явцад байгаль орчин бохирдох, газар эвдэгдэж сүйтгэх зэргээр байгаль орчинд сөрөг нөлөөлөл их байдаг тул тусгай зөвшөөрөл эзэмшигчээс байгаль орчныг нөхөн сэргээлэх арга хэмжээг авахуулах, хохирлыг нөхөн төлүүлэхийг иргэд шаардаж болно.</p> <p>Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг зөрчиж үйл ажиллагаа явуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчид хуульд зааснаар хариуцлага хүлээлгэх байгаль орчныг хамгаалах тухай хуулийг зөрчиж үйл ажиллагаа явуулсан, байгаль орчинд сөргөөр нөлөөлсөн тусгай зөвшөөрөл эзэмшигчид хариуцлага тооцох, хохирол арилгуулахыг шаардахаас гадна холбоогдох байгууллагад, снаал, хүсэлтээ гаргаж, шийдвэрлүүлэх эрхийг олгосон.</p>

<p>Газрын тосны тухай хууль 2014.07.01</p>	<p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт - Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: -“гэрээлэгч” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулсан компанийг;</p> <p>11 дүгээр зүйл. Гэрээлэгчийн эрх, үүрэг - Гэрээлэгч дараах эрх эдэлнэ: -байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулах;</p>	<p>Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй тохиолдод тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгийг байгаль орчныг нөхөн сэргээхэд ашиглуулахаар шаардах боломжтой.</p>
<p>Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль 1995.04.17</p>	<p>5 дугаар зүйл. Өргөдөл, гомдол гаргах эрх Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхтэй.</p>	<p>Иргэдийн төрийн байгууллагад өөрсдийн санал, шаардлагаа гаргах, шийдвэрлүүлэх боломжийг олгосон.</p>

<p>Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль 2014.01.09</p>	<p>11 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх - Түгээмэл тархацтай ашигт малтмалын асуудлаар аймаг, нийслэлийн Засаг дарга доор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: -хүний эрүүл мэнд, байгаль орчин, нөхөн сэргээлт, уурхайн хаалт болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих; 32 дугаар зүйл. Уурхайг хаах үед тавих шаардлага Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаах бол Ашигт малтмалын тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p> <p>37 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг цуцлах - Аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрлийг доор дурдсан үндэслэлээр цуцална: - тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх болон тусгай зөвшөөрлийн төлбөр төлөх шаардлагыг хангахгүй болсон; -тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөөгүй; -тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөөгүй, байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага дүгнэлт гаргасан; -тусгай зөвшөөрөл эзэмшигч нь түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах нэрээр өөр төрлийн ашигт малтмал хайж, ашигласан нь тогтоогдсон.</p>	<p>Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд хамаарах асуудлаар иргэд өөрсдийн байр суурийг илэрхийлэх, оролцох боломжтой.</p> <p>Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуульд заасан шаардлагыг хангаагүй , үүргээ биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах арга хэмжээг авах үндэслэл</p>
<p>Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2016.02.04</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>Иргэд өөрсдийн зөрчигдсэн эрхээ шүүхээр хамгаалуулах эрхтэй болохыг тусгасан.</p>

<p>Ашигт малтмалын тухай хууль 2006.07.08</p>	<p>41 дүгээр зүйл. Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна</p>	<p>Иргэдэд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс өөрт учирсан эд хөрөнгийн хохирлоо арилгуулахыг шаардах эрхийг олгосон.</p>
<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 2012.05.17</p>	<p>19 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага - Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. - Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p>	<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг зөрчиж үйл ажиллагаа явуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчид хуульд зааснаар хариуцлага хүлээлгэх</p>
<p>Зөрчлийн тухай хууль 2017.05.11</p>	<p>Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалахтай холбоотой журмын эсрэг зөрчил 7.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих 7.10. Газрын хэвлийн тухай хууль зөрчих 7.11. Ашигт малтмалын тухай хууль зөрчих 7.12. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль зөрчих 7.13. Газрын тосны тухай хууль зөрчих 7.14. Усны тухай хууль зөрчих 8.1. Газрын тухай хууль зөрчих</p>	<p>Ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаатай холбоотойгоор тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуульд заасан нийтлэг үүргээ биелүүлээгүй зөрчсөн үйлдлийг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулахаар Зөрчлийн тухай хуульд заасан.</p>

<p>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль 2017.05.18</p>	<p>1.18 Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал - Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг уг зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэр, энэ хуульд заасан харьяаллын дагуу явуулна. - Дараахь эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ: -мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Усны тухай хууль, Газрын тухай хуультай холбоотой зөрчлийг шалган шийдвэрлэнэ.</p>	<p>Танай нутагт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Усны тухай хууль, Газрын тухай хуультай холбоотой зөрчил гаргасан тохиолдолд орон нутгийнхаа мэргэжлийн хяналтын албаны хариуцсан мэргэжлийн хяналтын байцаагчид гомдол гаргаж, тухайн зөрчлийг шалган шийдвэрлүүлж болно.</p>
---	---	--



4.4.ОУ-ын гэрээ, конвенци

Хууль тогтоомжийн нэр /Батлагдсан огноо/	Зүйл заалт
<p>Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1946.12.10</p>	<p>22 дугаар зүйл. Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс бүрийн бүтэц, нөөц бололцоотой уялдуулан үндэсний хүч чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй.</p>
<p>Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь Конвенц 1992.03.02</p>	<p>2 дугаар зүйл. Энэхүү Конвенц болон түүнд оролцогч Талуудын Бага хурлаас батлан гаргаж болох эрх зүйн баримт бичгүүдийн эцсийн зорилго нь хийн мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг уур амьсгалын тогтолцоонд хүний үйл ажиллагааны улмаас нөлөөлж болох аюултай түвшинд хүрэхээргүйгээр тогтворжуулахад чиглэсэн Конвенцийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэхэд оршино. Энэ түвшинд эдийн засгийн цаашдын тогтвортой хөгжлийг хангах, хүнс тэжээлийн үйлдвэрлэлийг аюулд учруулахгүй байх, уур амьсгалын өөрчлөлтөд экологийн тогтолцоо аяндаа дасан зохицоход хангалттай тийм хугацаанд хүрэх ёстой.</p>
<p>Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц 1985.03.22</p>	<p>1 дүгээр зүйлийн 1. Талууд нь энэхүү Конвенцийн холбогдох Протоколын заалтын дагуу озоны үе давхаргын төлөв байдлыг өөрчлөх юмуу өөрчлөхүйц үйл ажиллагааны улмаас буй болсон эсхүл буй болж болзошгүй сөрөг үр дагавараас хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах талаар зохих арга хэмжээ авна.</p>
	<p>2 дугаар зүйлийн а) озоны үе давхаргын төлөв байдлын өөрчлөлтийн хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон хүний үйл ажиллагаа озоны үе давхаргад нөлөөлөх байдлыг үнэлэх, тэдгээрийг улам гүнзгий танин мэдэх зорилгоор байнгын ажиглалт, судалгаа хийх, мэдээлэл солилцох, зэргээр хамтран ажиллана.</p>
	<p>2 дугаар зүйлийн б) озоны үе давхаргын төлөв байдлыг өөрчилж байгаа эсхүл өөрчлөх боломж бүрдүүлж байгаа хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл гарч байгаа эсхүл гарч болохоор байгаа, тэр нь эрх зүйн, хяналтын хүрээнд хамаарах бол уг үйл ажиллагааг хяналтандаа авах, хязгаарлах, бууруулах эсхүл урьдчилан сэргийлэхэд шаардагдах эрх зүйн хийгээд удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах, зохих арга хэмжээний хөтөлбөрийн дагуу уялдуулан зохицуулсан хамтын ажиллагааг явуулна;</p>

Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц 1989.03.22

4 дүгээр зүйл. Ерөнхий үүрэг

Талууд дараахь арга хэмжээг авна. Үүнд:

-аюултай болон бусад хог хаягдлыг ашиглахад оролцож буй хүмүүсийг уг хаягдлаас үүсэх хортой нөлөөллөөс хамгаалах бүхий л арга хэмжээ авах ба хэрэв ямар нэг хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлэх тохиолдолд хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах хор уршгийг багасгах арга хэмжээ авах;

-аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагааг байгаль орчинд халгүйгээр ашиглах шаардлагын дагуу хязгаарлах тээвэрлэлтээс учирч болох сөрөг үр дагавараас хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалсан нөхцөлд тээвэрлэх үйл ажиллагааг явуулж байх;

-конвенцид Тал болж нэгдэн орсон улс төр болон эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагад хамаарах улс буюу хэсэг бүлэг улсуудад, ялангуяа хөгжиж буй улсуудад хэрэв тэд өөрсдийн хуулийн хүрээнд импортлохыг хориглосон буюу Талуудын анхны хуралдаанаар тодорхойлсон шалгуураар хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах боломжгүй гэж үзсэн тохиолдолд аюултай болон бусад хог хаягдлыг тэдгээрт экспортлохыг хориглох;

-аюултай болон бусад хог хаягдлыг тээвэрлэснээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд учирч болох хортой нөлөөллийн талаар тодорхой мэдээллийг хавсралт 5А-д заасны дагуу сонирхогч улсуудад хүргэхийг шаардах;

-аюултай болон бусад хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах боломжгүй бол түүнийг импортлохыг хориглох;

-аюултай болон бусад хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах аргыг боловсронгуй болгох, хууль бусаар тээвэрлэхээс сэргийлэх зорилгоор тийм хаягдлыг дамжуулан тээвэрлэхтэй холбогдсон мэдээлэл солилцох асуудлаар сонирхогч байгууллагууд болон бусад Талуудтай шууд буюу Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан хамтран ажиллах.

- Аюултай болон бусад хог хаягдал гаргадаг улс нь түүнийг байгаль орчинд халгүйгээр ашиглахыг энэ Конвенцийн хүрээнд шаардах үүрэгтэй бөгөөд харин ямар ч тохиолдолд импортлогч буюу дамжуулан өнгөрүүлэгч улсад шилжүүлж болохгүй.

- Хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг сайжруулах зорилгоор Талууд энэхүү Конвенцийн заалт болон олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн нэмэлт шаардлага тавихад энэхүү Конвенц ямар нэг байдлаар саад болохгүй.

8 дугаар зүйл. Дахин импортлох үүрэг

Энэхүү Конвенцийн заалтын дагуу сонирхогч улсууд зөвшөөрөл олгосон аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагаа гэрээний нөхцөлийн дагуу хэрэгжих боломжгүй тохиолдолд импортлогч улс экспортлогч орон болон Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдсэнээс хойш 90 хоногийн дотор буюу мөн сонирхогч улсуудтай тохиролцсон хугацаанд уул хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах өөр боломж буйг олж чадаагүй бол экспортлогч улс уг хаягдлыг экспортлогчид буцаах боломжийг бүрдүүлнэ. Үүнийг үндэслэн экспортлогч улс болон дамжуулан өнгөрүүлэгч аль ч Тал уг хаягдлыг экспортлогч улсад буцаахад ямар нэгэн саад болох ёсгүй.

9 дүгээр зүйл. Хууль бусаар тээвэрлэх

- Аюултай болон бусад хог хаягдлын тээвэрлэлтийг импортлогч болон зайлуулагч этгээдээс шалтгаалан хууль бус гэж үзвэл импортлогч улс, импортлогч болон зайлуулах үүрэг бүхий этгээдээр уг хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах ба шаардлагатай үед импортлогч улс өөрөө хууль бус тээвэрлэлтийн тухай мэдээлэл авснаас хойш 30 хоногийн дотор буюу эсхүл сонирхогч улсуудтай тохиролцож болох хугацааны дотор байгаль орчинд халгүйгээр зайлуулах арга хэмжээ авна. Сонирхогч Талууд хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах шаардлагатай арга хэмжээг хамтран авна.

- Экспортлогч, хаягдал гаргагч этгээд эсхүл импортлогч болон зайлуулах үүрэг бүхий этгээдэд хууль бус тээвэрлэлтийн хариуцлага хүлээлгэх боломжгүй байх тохиолдолд сонирхогч Талууд болон Талууд хамтран экспортлогч, импортлогч улсуудад буюу өөр газарт уг хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах арга хэмжээг яаралтай авна.

10 дугаар зүйл. Олон улсын хамтын ажиллагаа

- Аюултай болон бусад хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах ажлыг сайжруулах зорилгоор Талууд хамтран ажиллана.

- аюултай болон бусад хог хаягдлыг ашигласнаас хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хортой нөлөөлөлд хамтран хяналт тавина;

- аюултай болон бусад хог хаягдлыг гаргадаг үйлдвэрийг аль болохоор устгах зорилгоор одоогийн технологийг экологт сөрөг нөлөөлөлгүй, хаягдал бага гаргадаг болгон шинэчлэн сайжруулах, хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах талаар илүү үр дүнтэй арга зүйг шинээр боловсруулан хэрэглэх, эдгээр шинэ болон шинэчилсэн техник, технологи нэвтрүүлснээс эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр дагаврыг судлах талаар тус орнууд өөрсдийн үндэснийхээ хууль дүрэм, бодлогын хүрээнд хамтран ажиллана.

- аюултай болон бусад хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах технологи дамжуулах, ялангуяа энэ талаар туслалцаа шаардлагатай Талуудын техникийн чадавхийг нэмэгдүүлэх талаар өөрсдийн хууль, дүрэм, бодлогын хүрээнд идэвхтэй хамтран ажиллана;

-Хөгжиж буй орнуудын шаардлага, хэрэгцээг харгалзан үзсэний үндсэн дээр Талууд хоорондын болон олон улсын эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, ялангуяа /inter alia/ энэ асуудлаарх олон нийтийн ойлголтыг идэвхжүүлэх, аюултай болон бусад хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах үйл ажиллагааг өргөжүүлэх, хаягдал бага гаргадаг шинэ технологи нэвтрүүлэхэд нөлөөлөх зорилгоор хөхиүлэн дэмжинэ.

	<p>11 дүгээр зүйл. Хоёр болон олон тал, бүс нутгийн хэлэлцээр Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд, энэхүү Конвенцийн дагуу аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор Талууд нэгдүгээр заалтад заасан хоёр болон олон тал, бүс нутгийн энэхүү Конвенцид нэгдэн орохоос өмнө байгуулсан аливаа хэлэлцээрийн талаар Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ. Гагцхүү эдгээр гэрээ, хэлэлцээрүүд аюултай болон бусад хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах талаар энэхүү Конвенцийн шаардлагаг хангасан байх шаардлагатай</p> <p>13 дугаар зүйл. Мэдээлэл дамжуулах Талууд, аюултай болон бусад хог хаягдлыг тээвэрлэх, зайлуулах үед осол болон хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулах нөхцөл бий болсон тухай мэдээ авсан даруй холбогдох бусад улсуудад яаралтай мэдэгдэх ёстой.</p>
<p>Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт 1966.12.16</p>	<p>1 дүгээр зүйл. - Бүх ард түмэн зорилгодоо хүрэхийн тулд харилцан ашигтай байх зарчим дээр тулгуурласан олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа болон олон улсын эрх зүйгээр хүлээсэн аливаа үүрэгт хохиролгүйгээр байгалийн баялаг, эх нөөцөө чөлөөтэй эзэмшинэ. Аливаа ард түмнийг ямар ч тохиолдолд оршин тогтнох хэрэглүүрээс нь салгаж үл болно.</p> <p>3 дугаар зүйл. - Энэхүү Пактад оролцогч улсууд түүнд заасан эдийн засаг, нийгэм, соёлын бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эдлүүлэх нөхцлийг хангах үүрэгтэй.</p> <p>12 дугаар зүйл. - Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн бие бялдрын болон сэтгэцийн эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрхийг хүлээн зөвшөөрнө. - Энэхүү Пактад оролцогч улсууд энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах дараахь арга хэмжээг авна: -гадаад орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйг бүх талаар сайжруулах</p>

<p>Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц 1979.12.18</p>	<p>1 дүгээр зүйл. Энэхүү Конвенцийн зорилгоор “эмэгтэйчүүдийг алагчилах” гэсэн нэр томъёо нь гэрлэлтийн байдлаас үл хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон аливаа бусад салбарт эмэгтэйчүүдийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх, эсхүл үгүйсгэх үр дагавар, эсхүл зорилго бүхий хүйсээр ялгаварлах, үгүйсгэн гадуурхах буюу хязгаарлахыг хэлнэ.</p> <p>(е) аливаа хүн, байгууллага буюу аж ахуйн нэгжийн зүгээс эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгахад чиглэсэн зохистой бүх арга хэмжээг авах;</p> <p>7 дугаар зүйл. Оролцогч улсууд тухайн улсын улс төр, олон нийтийн амьдралд эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах үүднээс зохистой бүхий л арга хэмжээг авна, тухайлбал, эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй адил нөхцөлд дараахь эрхээр хангана:</p> <p>(с) тухайн улсын олон нийтийн болон улс төрийн амьдралтай холбогдол бүхий төрийн бус байгууллага, нийгэмлэгэд оролцох.</p> <p>14 дүгээр зүйл.</p> <p>1. Оролцогч улсууд хөдөө нутгийн эмэгтэйчүүдийн өмнө тулгарч буй онцлог асуудал болон тэднээс гэр бүлийнхээ эдийн засгийн амьдралд гүйцэтгэж буй чухал үүрэг, түүний дотор аж ахуйн таваарын бус салбарт гүйцэтгэж буй ажлыг анхааран үзэж, хөдөө нутгийн эмэгтэйчүүдийн хувьд энэхүү Конвенцийн заалтуудыг хэрэгжүүлэх талаар зохистой бүх арга хэмжээг авна.</p> <p>2. Оролцогч улсууд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр хөдөө нутагт эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах үүднээс эмэгтэйчүүд хөдөө нутгийн хөгжилд оролцож, түүнээс ашиг хүртэх талаар зохистой бүх арга хэмжээг авч, тэднийг дараахь эрхээр хангана</p> <p>(а) хөдөө нутгийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд бүх түвшинд оролцох;</p> <p>(f) хамтын нийгэмлэгийн бүх үйл ажиллагаанд оролцох;</p>
<p>Биологийн олон янз байдлын тухай конвенц 1992.06.05</p>	<p>Оршил, биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглах үйл хэрэгт эмэгтэйчүүд амин чухал үүрэг гүйцэтгэдгийг хүлээн зөвшөөрч, биологийн төрөл зүйлийг хамгаалахад чиглэгдсэн бодлогыг бүх түвшинд боловсруулж хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүдийг өргөн оролцуулах шаардлагатай байгааг баталсан.</p>
	<p>8 дугаар зүйл. Хэлэлцэн тохирогч Талууд аль болох боломжийнхоо хэрээр дараахь зүйлсийг хэрэгжүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - тэнцвэр нь алдагдсан экосистемийг нөхөн сэргээх, inter alia, зүй зохистой ашиглах төлөвлөгөө, бусад бодлого, хэтийн чиглэлийг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх замаар устгах аюулд байгаа төрөл зүйлийг нөхөн сэргээхэд туслалцаа үзүүлэх; - хүний эрүүл мэнд, биологийн төрөл зүйлийг тогтвортой ашиглах, хамгаалахад экологийн хортой үр дагавар учруулж болзошгүй биотехнологиос шалтгаалан хувирч өөрчлөгдсөн амьд бие, махбодийг гарган авч ашиглахад хяналт, хязгаарлалт, зохицуулалтын арга хэрэгслийг бий болгон дэмжих; - экосистемүүд , төрөл зүйлүүд, тэдгээрийн амьдардаг орчинд аюул занал учруулж байгаа гаднын зүйлийн интродукцийг арилгах, тэдгээрт хяналт тавьж устгах;

<p>Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966.12.16</p>	<p>1 дүгээр зүйл. Бүх ард түмэн өөрөө засан тохинох эрхтэй. Энэхүү эрхийнхээ дагуу тэд улс төрийн статусаа чөлөөтэй тогтоож, эдийн засаг, нийгэм, соёлоо чөлөөтэй хөгжүүлнэ. 3 дугаар зүйл. Энэхүү Пактад оролцогч улс түүнд заасан иргэний болон улс төрийн бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эдлүүлэх үүрэгтэй.</p>
<p>Мөнгөн усны тухай минаматагийн конвенц</p>	<p>3 дугаар зүйл. Мөнгөн усны нийлүүлэлтийн эх үүсвэр болон худалдаа - Тал тус бүр түүний хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдөр түүний нутаг дэвсгэр дээр мөнгөн усны үндсэн олборлолт хийгдэж байгаагүй бол, энэ өдрөөс эхлэн ийм олборлолт явуулахыг зөвшөөрөхгүй.</p> <p>10 дугаар зүйл. Мөнгөн ус агуулсан хаягдлаас бусад мөнгөн усыг байгаль орчинд аюулгүй аргаар түр хадгалах - Энэхүү зүйл нь 3 дугаар зүйлд заасан мөнгөн ус, түүний нэгдлийг түр хадгалахад хамаарах бөгөөд 11 дүгээр зүйлд заасан мөнгөн ус агуулсан хаягдалд хамаарахгүй. - Тал тус бүр түүнд энэхүү конвенцоор зөвшөөрсөн төрлийн хэрэглээний мөнгөн ус, түүний нэгдлийг түр хадгалахдаа доор дурдсан аливаа аргачлал болон шаардлагыг анхааралдаа авч, байгаль орчны аюулгүй байдлыг хангасан байх арга хэмжээг авна. Талуудын бага хурлаас мөнгөн ус, түүний нэгдлийг байгаль орчинд аюулгүй аргаар түр хадгалах талаарх зөвлөмжийг Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенцийн дагуу гаргасан аргачлал болон бусад холбогдох аргачлал, заавартай уялдуулан гаргана. Талуудын бага хурлаас түр хадгалахад тавигдах шаардлагыг хавсралтаар мөн баталж болно. - Мөнгөн ус, түүний нэгдлийг байгаль орчинд аюулгүй аргаар түр хадгалах чадавхийг бэхжүүлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд Талууд хоорондоо болон холбогдох засгийн газар хоорондын байгууллага, бусад аж ахуйн нэгжтэй хамтран ажиллана.</p>

11 дүгээр зүйл. Мөнгөн ус агуулсан хаягдал

Энэхүү конвенцийн зорилгоор “мөнгөн ус агуулсан хаягдал” гэж Талуудын бага хурлаас Базелийн конвенцийн холбогдох байгууллагатай хамтран тогтоож өгсөн босго хэмжээнээс дээш байгаа, энэхүү конвенцийн болон тухайн улсын хууль тогтоомжийн дагуу устгасан, устгах гэж байгаа, устгах шаардлагатайг тодорхойлсон дор дурдсан бодис эсхүл биетийг хэлнэ. Үүнд:

-Мөнгөн ус эсхүл түүний нэгдлээс бүрэлдэн тогтсон;

-Мөнгөн ус эсхүл түүний нэгдлийг агуулсан; эсхүл

-Мөнгөн ус эсхүл түүний нэгдлээр бохирдсон.

Дээрх тодорхойлолт нь мөнгөн усны үндсэн олборлолтоос бусад олборлолтын хаягдал хүдэр, чулуулгаас бусад эрдсийн хүдэр, уул уурхайн хаягдал чулуулаг нь Талууд бага хурлаас тогтоож өгсөн босго хэмжээнээс бага агуулгатай байвал хамаарахгүй.

Тал тус бүр мөнгөн ус агуулсан хаягдалтай холбогдох дараахь арга хэмжээг авна:

-Базелийн конвенцийн дагуу гаргасан аргачлал, Талуудын бага хурлаас тусгай хавсралтаар гаргах шаардлагыг үндэслэж мөнгөн ус агуулсан хаягдлыг байгаль орчинд аюулгүй байдлаар зохицуулна. Талуудын бага хурал шаардлага бүхий баримт бичгийг боловсруулахдаа Талуудын хог хаягдлын зохицуулалтын хууль, тогтоомж, хөтөлбөрийг харгалзан үзнэ;

-Талууд дахиж сэргээсэн, дахин боловсруулсан, цэвэрлэж авсан, шууд дахин ашигласан хаягдлыг зөвхөн конвенцоор зөвшөөрсөн хэрэглээнд ашиглана эсхүл байгаль орчинд аюулгүй аргаар устгана;

-Базелийн конвенцийн Талуудын хувьд зөвхөн энэхүү заалт болон Базелийн конвенцид нийцүүлэн байгаль орчинд халгүйгээр зайлуулахаас бусад шалтгаанаар олон улсын хил дамнуулан тээвэрлэхгүй байна. Базелийн конвенц үйлчлэхгүй олон улсын хил дамнуулан тээвэрлэх тохиолдолд Талууд тухайн тээвэрлэлтийг зөвхөн холбогдох олон улсын хэм хэмжээ, стандарт болон аргачлалыг харгалзан зөвшөөрнө.


Талууд дэлхийн, бүс нутгийн болон үндэсний хэмжээнд мөнгөн ус агуулсан хаягдлыг байгаль орчинд аюулгүй аргаар зохицуулах чадавхийг бий болгох, хөгжүүлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд хоорондоо болон холбогдох засгийн газар хоорондын байгууллага, бусад аж ахуйн нэгжтэй хамтран ажиллана.



	<p>12 дугаар зүйл. Бохирдсон газар</p> <ul style="list-style-type: none"> - Тал тус бүр мөнгөн ус эсхүл түүний нэгдлээр бохирдсон газрыг олж тогтоох, үнэлгээ хийхэд шаардлагатай стратеги боловсруулахад хүчин чармайлт гаргана. - Бохирдсон газраас үүсч болох аливаа эрсдлийг бууруулах үйл ажиллагааг явуулахдаа байгаль орчинд аюулгүй аргыг ашиглан явуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд бохирдсон газрын мөнгөн ус эсхүл түүний нэгдлээс байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийн үнэлгээг хийнэ. - Талуудын бага хурлаас бохирдсон газрын асуудлыг зохицуулах талаар дараахь арга зам, хэлбэрийг агуулсан зөвлөмж, аргачлал гаргана. Үүнд: <ul style="list-style-type: none"> -Бохирдсон газрыг олж тогтоох, шинж чанарыг тодорхойлох; - Олон нийтийн оролцоо; - Хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлэх эрсдлийн үнэлгээ; - Бохирдсон газраас үүсч болох эрсдлийн зохицуулалтын хэлбэрүүд; - Үр ашиг, зардлын тооцоо, дүгнэлт; болон - Гаргах үр дүнгийн үнэлгээ. - Талууд бохирдсон газрыг олж тогтоох, үнэлэлт, дүгнэлт өгөх, эрэмблэх, зохицуулах, шаардлагатай тохиолдолд нөхөн сэргээх зорилгоор стратеги боловсруулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хамтран ажиллана.
	<p>16 дугаар зүйл. Хүн амын эрүүл мэнд</p> <p>Талууд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> - Эрсдэлд өртөөд буй, нэн ялангуяа эмзэг бүлгийн хүн амыг олж тогтоох, хамгаалах зорилгоор хүн амын мөнгөн ус, түүний нэгдэлд өртөх байдлыг бууруулах шинжлэх ухааны үндэслэлтэй эрүүл мэндийн зааварчилгаа гаргах асуудлыг тусгасан стратеги, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд мөнгөн усны өртөлтийг бууруулах болон хүн амын эрүүл мэндийн болон бусад холбогдох салбарын оролцоотойгоор олон нийтийн боловсрол олгох зорилт тавих явдлыг урамшуулах; - Ажлын байранд мөнгөн ус, түүний нэгдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх болон боловсрол олгох шинжлэх ухааны үндэслэл бүхий хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхийг дэмжих; - Мөнгөн ус, түүний нэгдэлд өртөж хордсон хүн амд зориулан урьдчилан сэргийлэх болон эмчлэх эрүүл мэндийн үйлчилгээг дэмжих; болон - Мөнгөн ус, түүний нэгдлийн өртөлтөөс эрүүл мэндэд үзүүлэх эрсдлээс урьдчилан сэргийлэх, оношлогоо хийх, эмчлэх, ажиглалт хийх бүтцийн болон эрүүл мэндийн мэргэжлийн чадавхийг бий болгох, шаардлагатай тохиолдолд бэхжүүлэх. <p>Эрүүл мэндийн асуудлыг хэлэлцэхдээ Талуудын бага хурал дараахь зүйлийг харгалзан үзэх ёстой. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Шаардлагатай тохиолдолд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага болон бусад холбогдох засгийн газар хоорондын байгууллагатай зөвлөлдөх, хамтран ажиллах; болон - Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага болон бусад холбогдох засгийн газар хоорондын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох явдлыг хөхиүлэн дэмжих

4.5 Холбогдох дүрэм, журам

Хуулийн нэр	Зүйл заалт	Ач холбогдол
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/181, А/458 дугаар хамтарсан тушаал. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам батлах тухай	https://www.legalinfo.mn/annex/details/10253?law-id=14752	Уурхайн, хаалт нөхөн сэргээлттэй холбоотой журам
Баяжуулах болон боловсруулах үйлдвэр ажиллаж байх үед		
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/181, А/458 дугаар хамтарсан тушаал. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам батлах тухай	https://www.legalinfo.mn/annex/details/10253?law-id=14752	Баяжуулах болон боловсруулах үйлдвэрийн нөхөн сэргээлттэй холбоотой журам
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн А/155, А/132 хамтарсан тушаалын хавсралт “Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрэм”	https://www.legalinfo.mn/annex/details/11086?law-id=15445	Баяжуулах болон боловсруулах үйлдвэр ажиллуулахдаа эдгээр дүрмийг баримтлах шаардлагатай байдаг. Уг шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавих шалгуур болно.
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/205 дугаар тушаалын хавсралт “Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”	https://www.legalinfo.mn/annex/details/10183?law-id=14720	Баяжуулах үйлдвэр нь уг шаардлагыг хангаж үйл ажиллагаа явуулна.



Мэдээлэл авах цахим хуудаснууд

1. ЗГ- Засгийн газар - <https://zasag.mn/>
2. Иргэд, олон нийттэй харилцах төв -<https://www.11-11.mn/>
3. ХЭҮК- Хүний эрхийн үндэсний комисс- <https://nhrcm.gov.mn>
4. УУХҮЯ- Уул уурхайн яам - <http://www.mmhi.gov.mn/>
5. АМГТГ- Ашигт малтмал газрын тосны газар <https://mrgpm.gov.mn/>
6. БОАЖЯ- Байгаль орчин аялал жуулчлалын яам- <http://www.mne.mn/>
7. МХЕГ- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар- <http://inspection.gov.mn/>
8. ГЗБГЗЗГ- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар- <https://gazar.gov.mn/>
9. АТГ- Авилгатай тэмцэх газар –www.iaac.mn
10. ОУИТБС- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга www.eitimongolia.mn
11. Уул уурхайн гэрээ- www.iltodgeree.mn
12. ШҮҮХ - www.shuukh.mn